

**ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН  
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022.12.08

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт	Биелэлт	Үнэлгээ
<b>Нэг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд:</b>				
1.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлж, урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгон, улсын хэмжээнд нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх.	Урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгож, улсын хэмжээнд нэгдсэн нэг бодлогоор ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээр давхардалгүйгээр нэг удирдлагаар хангагдана.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Сар шинэ-2022”, “Тэнэмэл-1,2,3”, “Зөвийг зөвлөө”, “Цахим соёл”, “Мал мах-Хяналт”, “Шийдвэрлэлт”, “Carback”, “Арлын дугаар”, “Ломбард хяналт”, “Халаас”, “РС-бүртгэл”, “Халхавч”, “Эрэлч нохой-2022”, “Илрүүлэлт-Оргодол-2022”, “Тэрбум мод” аяны хүрээнд “Байгалиа бүтээе-I.II”, “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ”, “Залилан”, “Хичээл эхэллээ”, “Unsend”, “Намайг алгас” зэрэг тусгай арга хэмжээ 12, хэсэгчилсэн 1755, нийт 1760 арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна.	100
2.	Байгууллагын дотоодод болон эрхлэх асуудлын хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталж, холбогдох алба хаагчдад хариуцуулан хэрэгжүүлэх. /ГХУСА33-1.1/	Төлөвлөгөөний дагуу ажил арга хэмжээ нь хариуцах эзэнтэй болсноор төлөвлөгөөний биелэлт хангагдаж үр дүн гарна.	Цагдаагийн байгууллагаас 2022 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны салбар төлөвлөгөөг 4 бүлэг, 60 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад 2022 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн 9/3070 албан бичгээр хүргүүлж, биелэлт, үр дүнг тооцон Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд хүргүүлж ажилласан.	100
3.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх инфографик, шторк, контент болон сэрэмжлүүлгийг салбар, байгууллагын цахим хуудас, сайт, мэдээллийн самбарт тогтмол байрлуулж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх. /ГХУСА33-1.2/	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бүтээсэн контентийг цахим хуудас, байгууллагын мэдээллийн самбарт тогтмол байршуулснаар иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилнэ.	Хэвлэл, мэдээллийн байгууллагад 4500 удаагийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх цаг үеийн мэдээллийг өгч, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 35 цахим сайт, 57 нүүр хуудсаар дамжуулан иргэдэд мэдээ, мэдээллийг нэг цонхоор дамжуулж байгаагаас гэмт хэрэг, зөрчлийн талаар 877, урьдчилан сэргийлэх чиглэлээр 3310, алба хаагчийн үйл ажиллагаа, алдар гавьяаг алдаршуулах чиглэлээр 206, бусад 456 мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд түгээсэн.  “Монгол төрийн цагдаа” эмхэтгэлийн эмхэтгэлийн 2021 оны IV улирал, 2022 оны I-III улирлын нийт 4 дугаарыг бэлтгэн “Адмон” ХХК-иар тус бүр 4000 нийт 16,000 ширхэгийг хэвлүүлэн ХЗДХЯамны харъяа 8 агентлаг, Цагдаа, дотоодын цэргийн 52 анги, байгууллагад хуваарийн дагуу тараан олгож, 2022 оны IV дүгээр улирлын дугаарыг бэлтгэн ажиллаж байна.  Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагааг сурталчлах, иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ мэдээллийг түгээх ажлын хүрээнд “Амрыг эрье” 20 минутын нэвтрүүлгийн нийт 96 удаагийн дугаар бэлтгэж МҮОНТ-ийн 1, 2 дугаар суваг болон ЭХ ОРОН, БОЛОВСРОЛ, ETV, TV-5,	100

			<p>TV-4, TV-9, OTV, NEWS CHANEL, ТВ-6 зэрэг нийт 12 телевизээр <b>420</b> удаагийн давталттайгаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэн ажилласан.</p> <p>“Police podcast” хөтөлбөрийн хүрээнд төв орон нутгийн цагдаагийн газар, хэлтэстэй хамтран <b>31</b> удаагийн ярилцлага бэлтгэн түгээсэн.</p>	
4.	<p>Төрийн алба хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлж, авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх ажлыг сайжруулах. /ГХУСАЗЗ-1.3/</p>	<p>Алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлага дээшилж, авлига, албан тушаалын гэмт хэрэгт өртөхгүй байх, төрийн үйлчилгээ иргэдэд шуурхай хүрнэ.</p>	<p>Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны сахилга, хариуцлагын зөвлөгөөнийг энэ оны 01 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулж, алба хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, сахилга, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах зорилгоор сахилгын зөрчлийн бодит жишээн дээр тулгуурласан богино хэмжээний 42 киног анги, байгууллагуудад хуваарилан бэлтгүүлж, 9 төрлийн 17 видео шторкыг “Алба хаагчдын чөлөөт индэр” хаалттай фэйсбүүк группт байршуулж, алба хаагчдад мэдээлэл хүргэн, давхардсан тоогоор 58800 алба хаагч үзэж, 1300 алба хаагч санал, сэтгэгдлээ ирүүлсэн нь үйлдэгдэж буй зөрчлийг таслан зогсоох урьдчилан сэргийлэх, зөрчиж буй хууль, журмын ойлголтыг тайлбарлан хүргэсэн ажил, арга хэмжээ болсон.</p> <p>Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, төрийн алба хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх, ёс зүйг дээшлүүлэх, байгууллагын соёлыг тогтоох зорилгоор Авлигатай тэмцэх газраас улсын хэмжээнд зохион байгуулж буй “Зөв зөвд, шударга зөв” аяныг байгууллагын алба хаагчдад сурталчилж, “Авлигатай тэмцэх газар”, “АТГ-Олон нийтийн төв” пейж фэйсбүүк хуудаст QR кодыг уншуулан нэгдэх, дагах ажлыг зохион байгуулсан. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй “Зөв зөвд, шударга зөв” соён гэгээрүүлэх аяны хүрээнд “Өнөөдрийг маргаашийн бахархал болгоё” өдөрлөгийг энэ оны 5 дугаар сарын 20-ны өдөр Дотоод хэргийн их сургуультай хамтран төгсөх дамжааны 500 гаруй оюутныг хамруулж, авлигатай тэмцэхэд “ТАНЫ ХЭЛЭХ УРИА” үг зохиох уралдаан, “Чөлөөт индэр мэтгэлцээн”-ий тэмцээнийг зохион явууллаа.</p> <p>Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх тухайд E-Mongolia” төрийн үйлчилгээний нэгдсэн системд цагдаагийн байгууллагаас олгодог 13 төрлийн лавлагаа, үйлчилгээг нэвтрүүлснээс хойш өнөөдрийг хүртэл 2.256.655 хандалт авсан ба “Жолоодох эрхийн оноо”, Жолоочийн лавлагаа, мэдээлэл”, “Жолооны үнэмлэх солих, нөхөн олгох” лавлагаа, үйлчилгээ хамгийн эрэлт ихтэй байна.</p> <p>Бүртгэл хяналтын төвөөс Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх, галт зэвсэг, сум ашиглан спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, галт зэвсэг болон галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн улсын хилээр нэвтрүүлэх, галт зэвсэг худалдан борлуулах төвөөс галт зэвсэг худалдан авах зөвшөөрөл хүссэн иргэн, хуулийн этгээд Галт зэвсгийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан “Gun.police.gov.mn”, Галт зэвсэг худалдан борлуулах төвийн “GVS.police.gov.mn”, Гэрээт харуул</p>	100

			хамгаалалтын үйл ажиллагааны “Sas.police.gov.mn”, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн бүртгэлийн систем “EIS.police.gov.mn”-д хүсэлт илгээсний дагуу шаардлага хангаж байгаа иргэн, хуулийн этгээдэд зөвшөөрөл олгож байна.	
5.	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх агуулга бүхий нийтлэл, мэдээлэл бэлтгэн нэвтрүүлэх, түүнийг нийт мэдээлэлд эзлэх хувь хэмжээг тогтоох тухай журмын төслийг боловсруулж, батлуулах. /ГХУСАЗЗ-1.4/	Журмын төсөлд тусгуулах санал боловсруулж, хүргүүлсэн байна.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32.5-д “Энэ хуулийн 32.4-т заасан агуулга бүхий нийтлэл, мэдээллийг тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж, нийтэлж байгаа нийт мэдээлэлд эзлэх хувь, заавал нэвтрүүлбэл зохих нийтлэл, мэдээллийн доод хэмжээг хууль зүйн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж заасны дагуу “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээллийн эзлэх хувь, заавал нэвтрүүлбэл зохих нийтлэл, мэдээллийн доод хэмжээг тогтоох тухай журам”-ын төслийг боловсруулж, 2022 оны 5г/8477 дугаартай албан бичгээр алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас саналыг авч, нэгтгэн боловсруулж, 2022 оны 01/638 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.	100
6.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллага үнэ төлбөргүй нийтэлж, нэвтрүүлэх журмын төслийг боловсруулж, батлуулах. /ГХУСАЗЗ-1.5/	Журмын төсөлд тусгуулах санал боловсруулж, хүргүүлсэн байна.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32.3-д “Энэ хуулийн 32.2-т заасан хойшлуулшгүй мэдээллийг үнэ төлбөргүй яаралтай нийтэлж, нэвтрүүлэх журмыг хууль зүйн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж заасны дагуу “Хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр үнэ төлбөргүйгээр яаралтай нийтэлж, нэвтрүүлэх журам”-ын төслийг боловсруулж, 2022 оны 5г/8477 дугаартай албан бичгээр алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас саналыг авч, нэгтгэн боловсруулж, 2022 оны 01/638 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.	100
7.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах болон Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг урамшуулах журмыг боловсруулж, батлуулах. /ГХУСАЗЗ-1.6/	Журмын төсөлд тусгуулах санал боловсруулж, хүргүүлсэн байна.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/270 дугаартай тушаалаар баталсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцон тодорхой ажил зохиож, үр дүнд хүрсэн хүн, хуулийн этгээдийг урамшуулна.” гэж заасны дагуу урамшуулах хэлбэр, журмыг судлан боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт цагдаагийн байгууллагыг төлөөлөн Хуулийн хэлтсийн дарга ажиллаж, санал, дүгнэлт боловсруулсан. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34.3-т “Энэ хуулийн 34.1, 34.2-т заасны дагуу урамшуулах хэлбэр, журмыг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж заасны дагуу “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг урамшуулах журам”-ын төслийг боловсруулж, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас санал авч, нэгтгэн боловсруулж, 2022 оны 2/413 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Мөн дээрх журмын төсөлд саналыг 2022 оны 2/49 дугаартай албан бичгээр Монгол	100

			Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлсэн.	
8.	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулах, эрх бүхий байгууллагад хүргүүлэх. /ГХУСА33-1.7/	Хуулийн төсөлд тусгуулах санал боловсруулж, хүргүүлсэн байна.	Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсан. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Засгийн газраас 2021.03.19-нд УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль нь 7 бүлэг 41 зүйлтэй. Төсөлд согтууруулах ундааны хэрэглээ, түүний худалдаа, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны талаар шинэлэг 8 зохицуулалт, архидан согтуурах, согтууруулах ундааны хэрэглээг нэмэгдүүлэх зорилго бүхий аливаа үйл ажиллагааг хориглох шинэлэг 9 зохицуулалтыг тусгасан.	100
9.	Олон Улсын төсөл болон Үндэсний хөтөлбөр /Коломбо, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр гэх мэт/-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх. /ГХУСА33-1.8/	Хөтөлбөрийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн байна.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны энэ оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар тус газраас “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт, гэмт хэргийн нөхцөл байдал, өнгөрсөн онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж, үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих үйл ажиллагааны жил бүрийн төлөвлөгөөг хуралдаанаар хэлэлцэн баталж, хэрэгжилтийг зохион байгуулахаар шийдвэрлэсний дагуу “Алсын хараа 2050”, Монгол Улсын урт хугацааны бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, чиг үүргийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, сургаж мэргэшүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах, донтогчдод үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг шинэ шатанд гаргах талаар хэлэлцэж “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 247 дугаар тогтоолоор “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны ажиллах журам, бүрэлдэхүүн”-ийг шинэчлэн баталсан. Тус газраас “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны 2022 оны төлөвлөгөө”-ний хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил, арга хэмжээний тайланг гаргаж Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд хүргүүлсэн. Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний цагдаагийн газраас Монгол Улсын цагдаагийн байгууллагын хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх чадавхыг бэхжүүлэх чиглэлээр мансууруулах бодисын цахим мэдээллийн	100

			систем боловсруулж суурилуулах, мансууруулах бодис илрүүлэх зарим тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх зорилгоор 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 03 дугаар сарын 03-ны өдрүүдэд Монгол Улсад судалгаа хийхээр ирсэн төлөөлөгчдөд цахим шинжилгээний лаборатори байгуулах хэрэгцээ шаардлага, тулгамдаж буй асуудлын талаар танилцуулга хийсэн. Дээрх ажлын хүрээнд БНСУ-ын Үндэсний цагдаагийн газраас цахим шинжилгээний лаборатори байгуулах асуудал дээр дэмжиж, шаардлагатай төсөв хөрөнгийн талаар судалгаа хийж, хариу мэдэгдэхээр болсон.	
10.	Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах. /ГХУСАЗЗ-1.9/	Төлөвлөгөөнд заагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг хангасан байна.	Цагдаагийн байгууллагаас “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”, “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”, “Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх”, Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”-ийн хуралдаанд тус тус оролцож, 2021 онд хийсэн ажлаа тайлагнаж, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталсан. “Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”-ийг татан буулгаж, Зам тээврийн хөгжлийн яамны дэргэдэх “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөл”-тэй нэгтгэх шийдвэр гарсан. “Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөлийн хурал 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулагдаж “Хүүхэд хамгаалал түншлэлийн компакт гэрээ”-г 2022 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний төслийг гишүүдэд танилцуулан санал хэлэлцүүлж батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн хуралд 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр цахимаар оролцож “Мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх санал”-ын талаар мэдээлэл хийсэн. Хурлаар 3 асуудлыг шийдвэрлүүлэхээр хэлэлцүүлсэн. Үүнд: Малын тоо толгойн албан татварын тухай хуулиар төсөвт цугларч буй хөрөнгөнөөс тодорхой хувийг мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах хуулийн зохицуулалтыг хийх. /аймгийн ГХУССЗ-д санг орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор байгуулах/ “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”-өөс мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулахад шаардагдах төсөв, хөрөнгөний тодорхой хувийг шийдвэрлэж байх. “Алдсан олдсон болон түр хугацаагаар саатуулагдсан малыг харгазлах хашаа”-г байгуулахад шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлүүлэх зэрэг саналыг дэвшүүлсэн.	100
11.	“Гэмт хэргийн цагаан ном-2021” эмхтгэлийг бэлтгэн гаргах. /ГХУСАЗЗ-1.13/	“Гэмт хэргийн цагаан ном-2021” эмхтгэл хэвлэгдсэн байна.	Монгол Улсад 2021 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал товхимол номыг бэлтгэн 250 ширхэгийг энэ оны 01 дүгээр сарын 31-ны өдөр	100

			хэвлүүлж, Хууль зүй дотоод хэргийн яам, цагдаагийн байгууллагын харьяа холбогдох нэгж, эрдэм шинжилгээний байгууллагуудад хүргүүлсэн. Дээрх товхимол номны 2021 оны цувралын зохиогчийн эрхийг Цагдаагийн Ерөнхий газрын нэр дээр бүртгүүлж, Оюуны өмчийн газрын 13763 дугаар бүхий гэрчилгээг авсан.	
12.	Гадаадад гэмт хэргийн хохирогч болсон иргэдэд үзүүлж буй эрх зүйн болон санхүүгийн дэмжлэг тусалцааг нэмэгдүүлэх. /ГХУСА33-1.16/	Эрх зүйн болон санхүүгийн дэмжлэг нэмэгдсэн байна.	Тагнуулын ерөнхий газрын Нийслэл дэх тагнуулын газар, Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс хамтран Цахим орчинд нийтлэгдсэн “Зүүн Өмнөд Азийн орнуудад Англи хэлний орчуулга хийх хүнийг зардлыг нь дааж өндөр цалинтай ажилд авна” гэх хуурамч зарын дагуу Мьянмар улсын “КК Парк” гэх газарт очсон 12 иргэнийг нь хэн болохыг нь тодорхойлон Гадаад харилцааны яамны Консулын газар, Хүйсийн тэгш эрх төв ТББ, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын дэмжлэг оролцоотойгоор эх оронд нь аюулгүй буцааж ирүүлсэн.	100
13.	Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон улсын сайн туршлагыг хэрэгжүүлэх боломжийн чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгуулах./ГХУСА33-1.18/	Хэлэлцүүлэг зохион байгуулж, зөвлөмж хүргүүлсэн байна.	Зам тээвэр хөгжлийн яаманд хэрэгжих “Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ нэвтрүүлэх” ажлын хүрээнд БНСУ-ын “Койка” ОУ-ын байгууллага, “Дэлхийн банк”-ны судалгааны багтай уулзалт, хэлэлцүүлгийг “ЗХАБ-ын мэдээллийн сан”-г бүрдүүлэх хэрэгцээ, шаардлагын талаар мэдээлэл солилцох байдлаар зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газар, ОУ-ын сэргээн босголт, хөгжлийн банк /Дэлхийн банкны/-тай байгуулсан 100сая ам.долларын санхүүжилттэй “УБ хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл /9257-MN/-ийг хэрэгжүүлэхээр байгуулсан гэрээнд “Тээврийн ухаалаг систем ITS”, “Ухаалаг авто зогсоолын менежментийн систем” гэсэн хоёр төслийг 20сая ам.долларын санхүүжилтээр 2023 оны 2-р улиралд багтаан эхлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд ТЦА-ны шинээр баригдаж буй байранд дээрх 2 ухаалаг системийн техник, тоног төхөөрөмжийг суурилуулж, нэгдсэн удирдлагын системтэй болгох ажлыг тусгуулсан. Замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах зорилгоор “ОУ-ын Автомашины Холбоо” /Fédération Internationale de Automobile “FIA”/ холбооноос гаргасан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын алтан дүрэм”-ийн ололттой талыг Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн холбогдох заалтуудтай уялдуулж, 2022 онд шинээр 10 төрлийн нөлөөллийн ажил, арга хэмжээг “Зөвийг хэвшүүлье” уриалга дор зохион байгуулж, үр дүнг тооцсон. Гадаадын зарим улсын замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой эрх зүйн зохицуулалт, хариуцлагын тогтолцоог судлах ажлын хүрээнд 37 улсын эрх зүйн зохицуулалтыг судалж, 107 хуудас судалгааны материалыг үйл ажиллагаанд ашиглаж байна. Тухайлбал: Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчилд хүлээлгэх шийтгэлийг гадаадын 18 улс /Австрали, Англи, Турк г.м/-тай харьцуулан судалж, Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үүрэг бүхий ХЗДХЯ-ны ажлын хэсэгт хүргүүлсэн.	70

			Гар утасны “Clubhouse” аппликейшн ашиглан “Согтууруулах ундаа ба тээврийн хэрэгсэл”, “Мотоциклийн стандарт хэрэглээ ба бодит байдал” сэдвүүдээр цахим хэлэлцүүлэг, “Монголын автомашин мотоциклын спортын холбоо”, “Монголын Авто Мастеруудын холбоо”, “Монголын бартаат замын авто спортын холбоо”, “Хүннү олон улсын мото холбоо”, “Сур-рон цахилгаан дугуй холбоо” зэрэг 5 төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан уулзалт хэлэлцүүлгийг тус тус 1 удаа зохион байгуулж, цахим хуудсаар иргэд, олон нийтэд түгээсэн нь 9510 хүнд хүрсэн байна.	
14.	Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам, тээврийн хэрэгсэл жолоодоход харшлах эм, бэлдмэл, тээврийн хэрэгсэлд байх эмийн сангийн иж бүрдлийн жагсаалт, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журам зэрэг холбогдох эрх зүйн зохицуулалтуудыг батлах, боловсронгуй болгох. /ГХУСА33-1.19/	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан заалт хэрэгжиж, эрх зүйн орчин сайжирна.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны 06-р сарын 15-ны өдрийн А/315 дугаар тушаалаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт зааснаар Эрүүл мэндийн сайдын батлах “Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам, үзлэгийн хуудасны загвар, үзлэг явуулах эрх бүхий эмнэлгийн байгууллагын жагсаалт, тээврийн хэрэгсэл жолоодоход харшлах эм, бэлдмэл, тээврийн хэрэгсэлд байх эмийн сангийн иж бүрдлийн жагсаалт, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журам”-ын төслийг боловсруулах ажлын хэсгийг 16 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хийгдэх ажлын удирдамжийг баталсан. Дээрх ажлын хэсэгт 1 алба хаагч томилогдон ажилласан бөгөөд “Жолоочийн эрүүл мэндийн үзлэг хийх журам”, мөн “Тээврийн хэрэгсэлд байх анхны тусламжийн эм, жолоо барихад харшлах эм бэлдмэлийн жагсаалт”-ын төслийг боловсруулахад оролцож, бэлэн болсон журмын төсөлд тусгах саналыг энэ оны 9 дүгээр сард хуралдсан ажлын хэсгийн хуралдаанд хэлэлцүүлж ажилласан. Ажлын хэсгийн хурал дахин товлогдоогүй байгаа бөгөөд холбогдох журмын төслүүд хараахан батлагдаагүй байна.	70
15.	Гудамж, зам талбайд ашиглагдаж байгаа камерын ашиглалт, засвар үйлчилгээг сайжруулах, шинээр суурилуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.	Тодорхой төрлийн гэмт хэргийн гаралт буурч, илрүүлэлтийн хувь нэмэгдсэн байна.	Олон улсын сайн туршлага, дэвшилтэд технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран нийслэл хотын теле камерын тоог нэмэгдүүлж, ашиглалтыг үр дүнтэй болгох “Аюулгүй хот”-ыг бий болгох зорилтын хүрээнд өнөөгийн нийгэм эдийн засгийн нөхцөл байдалд тохируулан камерын хяналттай “Ногоон бүс” төслийг хэсэгчлэн зохион байгуулах ажлын хүрээнд эхний ээлжинд Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо 1-р дөчин мянгатын нутаг дэвсгэрийн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээгээр дүүргийн хэмжээнд хулгайлах, халаасны хулгайн гэмт хэргийн 31.7 хувь үйлдэгддэг, өдөртөө Улаанбаатар хотын иргэдийн 60 орчим хувь нь зорчин өнгөрдөг, аж ахуй нэгжийн төвлөрөлт, дэд бүтэц зэрэг хүчин зүйлд тулгуурлан сонгон авч теле камерын хяналтад бүрэн оруулах ажлыг амжилттай хэрэгжүүлсэн. Олон улсад хэрэгжиж буй “Green zone” төсөл нь дэлхийн 3 орон буюу Бүгд Найрамдах Солонгос улсын Сөүл хот, Оросын холбооны улсын Москва хот, Англи улсын Лондон хотуудад амжилттай хэрэгжиж, камерийн хяналтаар нийт гэмт хэргийн 45-47 хувийг илрүүлсэн тэргүүн туршлага байгааг үндэслэн Чингэлтэй дүүргийн 1-р хорооны 19.7 га газрын 61 цэгт 145 камер	100

			<p>шинээр байршуулах, түүнд шаардагдах төсөв тооцоонд тулгуурлан төр, хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллага, иргэдийн хамтын санхүүжилтын дэмжлэгтэйгээр камер суурилуулах ажлыг зохион байгуулсан.</p> <p>“Ногоон бүс”-д Монгол Улсын телехяналтын тоног төхөөрөмжийн (MNS6423:2019) стандартыг хангасан 4 мегапиксел бүхий үзүүлэлт бүхий 145 ширхэг камерыг 61 цэгт суурилуулан теле хяналтын нэгдсэн сүлжээнд холбон 24 цагаар цагдаагийн байгууллагаас хяналт тавин ажиллаж байна. Телехяналтын нэгдсэн төв нь нийтийн эзэмшлийн гудамж, талбайд суурилуулсан камеруудын дүрсийг нэгтгэж харах зорилго бүхий 25 ширхэг ханан дэлгэц бүхий нэг дор 800 ширхэг камерийн дүрсийг хянах стандартын шаардлагад нийцсэн зориулалтын шал, хана, хөргүүр зэргийг цогцоор нь шийдвэрлэсэнээр онцлог юм.</p> <p>Түүнчлэн Улаанбаатар хотод олон улсын жишигт нийцсэн “Ногоон бүс” бүхий хороо анх удаа байгуулагдсан нь иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан, тэргүүн туршлага болохуйц ажил болсон.</p> <p>Мөн Нийслэлийн засаг даргын 2022 оны А/1369 дугаартай захирамжаар 800,0 сая төгрөгийг шийдвэрлүүлж Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Удирдлагын төвийн серверийн өрөөний техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, автобусны буудлын хяналтын цэг байгуулах (103 буудал), автобусны хяналтын цэгийг тус төвтэй холбох сүлжээ, дэд бүтцийн ажлын гэрээ байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж, НЗДТГ-ын даргад хүргүүлснээр “Бодь Электроникс” ХХК-тай хамтран ажиллаж байна.</p>	
16.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх ажлыг олон талт хэлбэрээр идэвхжүүлэх.		<p>“Найрсаг Улаанбаатар-2” арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын захирамжаар “Оюутан цагдаа-2022” арга хэмжээнд шаардагдах 157.176.000 төгрөгийн төсвийг шийдвэрлүүлж жуулчид олноор явдаг эргүүлийн чиглэл, байршлыг А, Б, В бүс болгон ангилж их, дээд сургуулийн 150 гадаад хэлний мэдлэгтэй оюутан, Дотоод хэргийн их сургуулийн 2 дугаар дамжааны 60 сонсогчдыг үйлдвэрлэлийн дадлагын хугацаанд тус арга хэмжээнд татан оролцуулж, 3 ээлжээр /10.00-14.00, 14.00-18.00, 15.00-21.00/ цагийн хооронд эргүүлийн 75 чиглэлд ажиллуулсан.</p> <p>Оюутан, сонсогч нар Цагдаагийн байгууллагын 102 тусгай дугаарт гэмт хэргийн 15, зөрчлийн шинжтэй 42 дуудлага мэдээлэл өгч, дотоодын 3382, гадаадын 2865 иргэнд хэлмэрчилж, туслалцаа үзүүлэн 1154 гарын авлага, зурагт хуудас, зөвлөмж, сэрэмжлүүлэг тараан, эцэг эх, асран хамгаалагчаасаа төөрсөн 14 бага насны хүүхдийг ар гэрт нь хүлээлгэн өгч ажилласан.</p> <p>Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийг төвтэй хамтран жуулчид, гадаадын иргэдэд оюутан цагдаагийн үйлчилгээ таалагдсан, эерэг сэтгэгдэл төрүүлэхүйц мэдээллийг олон нийтийн сүлжээгээр 2315 түгээлж хийж, 8967 иргэн үзэж, 151 сэтгэгдэл бичиж давалгаа үүсгэж, 2 контент бүтээж, 7 телевиз, 15 сайтаар иргэд, олон нийтэд хүргэж ажилласнаар гадаадын иргэн гэмт хэрэгт өртөж хохирсон 22 тохиолдол бүртгэгдсэн нь</p>	90



			<p>өмнөх оны мөн үеэс 9 нэгжээр өссөн бол гэмт хэрэгт холбогдсон тохиолдол 4 бүртгэгдэж 2 нэгжээр буурсан эерэг үзүүлэлттэй байна.</p> <p>Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, хүн ам, нутаг дэвсгэрийн онцлогтой уялдуулан тухайн жил ажиллах олон нийтийн цагдаагийн тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хүсэлтийг аймаг, нийслэлийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлж, энэ онд Улсын хэмжээнд нийт 700, үүнээс нийслэлд 230, тээврийн цагдаагийн албанд 52, орон нутагт 289 олон нийтийн цагдаа орон тоог тогтоолгон нийслэлд 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 03 дугаартай Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор орон тоог 230 байхаар тогтоож, төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээний 9 дүгээр зэрэглэлийн 1 дүгээр шатлалтай /ТТ-9-1/ дүйцүүлэн 641.363 төгрөгийн урамшуулал олгохоор шийдвэрлүүлсэн.</p> <p>“Олон нийтийн цагдаатай байгуулах хөдөлмөрийн гэрээний загвар”-ын дагуу гэрээг байгуулан ажилласан бөгөөд дүрмийн 5.2 дахь хэсэгт заасны дагуу аймаг, дүүргийн Засаг даргад цагдаагийн газар, хэлтсүүдээс 2022 оны олон нийтийн цагдаагийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт, ажлын тайлан, үнэлгээг хүргүүлж, 2 жил үр дүнтэй ажилласан 35 олон нийтийн цагдааг 2022 онд цагдаагийн алба хаагчаар дэвшүүлэн томилуулсан.</p>	
17.	Цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гудамж, талбайд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах.		<p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын өгсөн үүрэг, санаачлагаар Нийслэлд морьт эргүүлийн үйл ажиллагааг өргөтгөх төслийг шинээр боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газрын дарга нарт танилцуулж төсөв хөрөнгийг шийдвэрлүүлснээр энэ оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс Нийслэлийн Туул голын эрэг дагуу “Завьт эргүүл” ажиллуулж Хэрлэн, Туул гол дагуу авто эргүүлийн 4 чиглэлд 8 алба хаагч 24 цагаар, явган эргүүлийн 44 чиглэлд 88 алба хаагч 2 ээлжээр, завьт эргүүлийн 4 чиглэлд 12 алба хаагч, 4 завь, 4 автомашинтай, морьт эргүүлийн 10 чиглэлд 20 алба хаагч, мотоциклтэй эргүүл 6 чиглэлд 12 алба хаагч 2 ээлжээр нийт 68 чиглэлд 116 алба хаагч 8 автомашин, 4 завь, 10 морь, 6 мотоциклтэй үүрэг гүйцэтгэж гэмт хэрэг, зөрчлийн 1322 дуудлага, мэдээлэлд ажиллаж автомашин 10956, хүн 24042 шалгаж, зөрчил гаргасан 1067 хүнд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд арга хэмжээ тооцож, 186 хүнийг эрүүлжүүлэх байранд хүргэсэн.</p> <p>Гол, усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 405 санамж, сэрэмжлүүлэг бүхий зурагт хуудас тарааж, 2310 иргэнд яриа таниулга хийж хэвлэл мэдээлэл болон цахим мэдээллийн хэрэгслээр 10575 удаа сурталчилж, гол дагуу сэрэмжлүүлэх самбар 80 ширхгийг байрлуулсан.</p> <p>Нийслэлийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор үүрэг гүйцэтгэж байгаа морьт, нохойт, завьт, мотоциклд эргүүлийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэхээр мэдээлэл, сурталчилгааны</p>	100

			байгууллагатай хамтарч гэрээ байгуулан ажиллахаар НИТХ-ын даргад танилцуулснаар 10 сая төгрөгийг шийдвэрлүүлж, “Монголын сайн сайхны төлөө нийгмийн ил тод байдлын нэгдсэн судалгаа” ТББ-тай “Ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулан ажилласан.	
18.	Залилах гэмт хэргийн гаралтыг бууруулах, бүртгэгдсэн хэргүүдийн шийдвэрлэлтийг ахиулах, иргэдэд учирсан хохирлыг барагдуулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажлын хэсэг байгуулж ажиллах.	Залилах гэмт хэргийн гаралт буурсан байна	<p>Цагдаагийн байгууллагаас “Залилах” гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хэргийн шийдвэрлэлтийг ахиулах үүрэг бүхий ажлын хэсгийг ЦЕГ-ын Тэргүүн дэд даргын 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/07 дугаар тушаалаар байгуулж, ажлын хэсгээс хийж гүйцэтгэх ажил төлөвлөгөөг боловсруулан 03 дугаар сарын 15-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргаар батлуулсан.</p> <p>“Залилах” гэмт хэргээс иргэн, хуулийн этгээдийг өртөхөөс урьдчилан сэргийлэх, хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хор уршгийг таниулах зорилгоор энэ оны 06, 09 дүгээр сард 2 удаа улсын хэмжээнд урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж иргэн, хуулийн этгээдийг залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр бэлтгэсэн нийт 95 сэрэмжүүлэг мэдээллийг төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын цахим орчинд түгээснийг 1.596.893 хүн дэмжиж, 252.079 хүн эерэг сэтгэгдэл үлдээж, 1.774.577 хүн бусадтай хуваалцаж, давхардсан тоогоор 10.024.438 хүнд хүрсэн байна.</p> <p>Уг арга хэмжээний хугацаанд 858 залилах гэмт хэрэг бүртгэгдсэнээс 154 хэрэг буюу 17.9 хувийг шүүхэд шилжүүлж, 191 хэрэг буюу 22.2 хувийг хааж, 605 хэрэг буюу 70.5 хувийг бусад хэрэгт нэгтгэн шийдвэрлэж, энэ төрлийн гэмт хэргийн гаралт 4,7 хувиар буурсан эерэг үр дүн гарсан.</p> <p>Мөн “Бүү шилжүүл” уриатай “Unsend” аяныг 11 дүгээр сарын 14-нөөс 29-ний өдрүүдэд цахим орчинд “Залилах” гэмт хэргээс урьдчилан олон талт арга хэмжээ зохион байгуулж “Lebo”, “Хулан шоу” интертаймент үйлчилгээ үзүүлэгч компаниудтай хамтран богино хэмжээний видео-4, постер-8-г бэлтгэн Монголбанк, Монголын банкны холбооны сайт, пэйж хуудсуудаар болон бусад дагагч өндөртэй пэйж хуудас, группуудээр дамжуулан олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан.</p> <p>Банк бус санхүүгийн байгууллагын холбооны гишүүд болох нийт 41 иргэнд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Татвар төлөхөөс зайлсхийх, Залилах гэмт хэргийн ойлголт сэдвээр тус тус сургалт зохион байгуулсан.</p> <p>Хөндлөнгийн, хараат бус менежментын тогтолцооны стандартын баталгаажуулалтын үйл ажиллагаа эрхэлдэг “МонСертф” ХХК-с “Дэлхийн чанарын долоо хоног”-г тохиолдуулан зохион байгуулсан “Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо” сэдэвт уулзалтад Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа С.Тайван “Цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдвээр нийт 65 иргэнд мэдээлэл хийсэн.</p>	100
<b>Хоёр. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай чиглэлийн хүрээнд:</b> <b>2.1. Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>				

19.	<p>Замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, дүрэм журмын хэрэгжилтийг хангах зорилгоор -40 градуст ажиллах боломж бүхий дүрс бичлэгийн техник, тоног төхөөрөмжийг засварлах, сэлбэх, шинэчлэн суурилуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх. /ГХУСА33-2.1.1/</p>	<p>Зам тээврийн осол, гэмт хэрэг буурах ба хэрэг, зөрчил гарсан тохиолдолд нотлох баримтын шаардлага хангагдана.</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд, ЦЕГ-ын Дарга, Тэргүүн дэд дарга, ТЦА-ны дарга, Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын дарга нарын хамтарч болон дангаар баталсан ажлын хэсэг байгуулах тухай 32 удаагийн тушаал шийдвэрийн хүрээнд теле хяналтын камерыг ашиглах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, байнгын болон цагийн менежментийн хяналт бүхий цэг, байршлыг камержуулах, авто замын хяналтыг сайжруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зэрэг нийт 27 ажлын хэсэгт тээврийн цагдаагийн албаны хариуцсан албан хаагчид томилогдон ажиллаж, камержуулалттай холбоотой ажлын уялдаа холбоог хангуулах, “Нэгдсэн хяналт, удирдлагын төв” байгуулах бодлогыг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож байна.</p> <p>Нийслэлийн Засаг даргын зөвлөх болон харьяа агентлагийн холбогдох албан тушаалтнуудад “Замын хөдөлгөөнт эргүүл Traffic Patrol” төслийг танилцуулж, шаардлагатай 5.7 тэрбум зардлыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/385 дугаартай захирамжийг гаргуулж, хууль тогтоомжийн дагуу шаардлагатай техник хэрэгслийн худалдан авалт хийгдсэн.</p> <p>Нийслэлийн ГХУСА33-д саналаа танилцуулж, сургалтын системд 60 сая, хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардлагатай тандагч 250, согтуурлын зэргийг тогтоох драйвер багаж 10, энгэрийн камер 100 ширхгийг авахад шаардлагатай нийт 289,8 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын А/216 дугаар тушаалаар “Замын хөдөлгөөний зохицуулалт, төлөвлөлтийн нэгдсэн систем” төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдан, Улаанбаатар хотын хэмжээнд байрлах ашиглалтын хугацаа дууссан 80 гэрлэн дохиог иж бүрэн шинэчлэх, шинээр баригдсан авто зам, гудамж, уулзваруудад нэн шаардлагатай 40 цэгт гэрлэн дохиог шинээр суурилуулах, Энхтайваны өргөн чөлөөний 47 цэг, нийслэлийн хэмжээнд байрлах 161 уулзварт RFID төхөөрөмж болон тээврийн хэрэгслийн дугаар таних, зөрчил илрүүлэх системд техникийн тодорхойлолт, шаардлагыг боловсруулах ажлыг хамтран гүйцэтгэж байна.</p> <p>Авто замын гэрлэн дохиог нэгдсэн хяналтын сүлжээнд холбон автоматжуулах, хиймэл оюун ухаанд суурилсан технологи нэвтрүүлэх техник, технологийн шийдлийг боловсруулж, хэрэгжүүлэхээр Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/424 дугаартай захирамжаар байгуулагдсан “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” ОНӨТҮГ-ийн хэлтсийн даргын ахалсан 9 хүний бүрэлдэхүүнтэй багийг байгуулж, “Улаанбаатар хотын зам тээврийн ухаалаг системийг шинэчлэх ерөнхий санал”-ыг боловсруулж, шаардагдах 20,0 сая ам долларын санхүүжилт авахаар Монгол Улс болон Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны 9257 MN дугаартай гэрээ байгуулагдаад байна.</p>	100
-----	---	--	--	-----

			Дээрх гэрээнд Нийслэлийн авто замын сүлжээ, дэд бүтцийг өргөтгөх ажлаас гадна “Тээврийн ухаалаг системүүд”, “Авто зогсоолын удирдлагын ухаалаг систем”-ыг нэвтрүүлэх ажлыг 2023-2026 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан.	
20.	Хот, суурин газрын зам дагуу болон төлөвлөгдсөн замын байгууламжийн талбайд олгосон хууль бус газар олголтод хяналт шинжилгээ үнэлгээ хийх, авто зам дагуу аюултай нөхцөлд байрлах айл, өрхийг аюулгүй байршилд нүүлгэн шилжүүлэх, тэднийг аюул, ослоос урьдчилан сэргийлж аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд замын дэглэм зөрчсөн байдалд нэг бүрчилсэн ажил арга хэмжээг Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу нэг бүрчилсэн арга хэмжээ авах асуудлыг шийдвэрлүүлэх. /ГХУСА33-2.1.2/	Иргэд, олон нийтийг учирч болох ослын аюулаас урьдчилан сэргийлнэ.	Тээврийн цагдаагийн албанаас явган зорчигчдыг чөлөөтэй, аюулгүй зорчих нөхцөл бололцоогоор хангах зорилгоор албанаас энэ оны 5 дугаар сард үзэгдэх орчин хязгаарлаж явган хүний зам дээр байрлуулсан нийт 163 объект, барилга байгууламжийн судалгааг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн.  Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/388 дугаар захирамжийн хүрээнд Улаанбаатар хотын хэмжээнд 188 байршилд 4860 граж буулгаж газар чөлөөлөх ажил хийгдэх үед тус албанаас байршил тус бүрд барилгын ажил хийгдэх үед хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажилласан.	
21.	“Зөвийг хэвшүүлэе” аяныг хамгаалалтын бүс, мотоциклын малгай, хүүхдийн хамгаалах суудал, явган хүний гарцаар нэвтрэх соёлыг хэвшүүлэх олон нийтэд ухуулан таниулах, сургалт, нэвтрүүлэг олон нийтийн хэрэгслээр явуулах, хяналт шалгалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах. /ГХУСА33-2.1.3/	Орон нутгийн зам дахь осол, хэргийн тоо буурч, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг сайжирна.	Олон улсын аюулгүй жолоодлогын 10 дүрмийг Монгол улсын нутаг дэвсгэрт нутагшуулах зорилгоор “Зөвийг хэвшүүлэе” уриатай 10 төрлийн нөлөөллийн арга хэмжээний хүрээнд явган зорчигчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор “Гэрлээр анхааруулъя”, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой “Гар утас”, Унадаг дугуй, цахилгаан дугуй, мопед, мотоциклын жолоочийн аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Хамгаалах малгай”, Явган зорчигчийн аюулгүй байдлыг хангах, сургууль орчмын бүсэд хүүхдийг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн аюулгүй тээвэртэй холбоотой “Явган зорчигчийн аюулгүй байдал-Сургууль орчмын бүс-Хүүхэд”, Орон нутгийн замд хурд хэтрүүлэх, ядарсан үедээ жолоо барих, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ”, Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих халтиргаа гулгааны үед зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Дугуй” нөлөөллийн арга хэмжээг тус тус зохион байгуулж, биелэлт үр дүнг тооцож ажилласан.  Монгол ёс заншил, өв уламжлалд тулгуурлан шинэлэг, ойлгомжтой хэлбэрээр зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнд оролцогчдын эрх зүйн мэдлэгийг сайжруулах зорилгоор /Traffic podcast/ подкаст ярилцлагын 1 удаагийн дугаарыг Гандан тэгчилэн хийдтэй хамтран замын хөдөлгөөнд дүрэмгүй оролцохын хор уршгийг бурхны шашинд хэрхэн авч үзсэн байдаг талаар, ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвтэй хамтран “Амрыг эрье” нэвтрүүлгийн нэг удаагийн дугаарыг малчдыг мотоциклын осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Төв аймгийн Баянцогт сумын нутаг дэвсгэрээс, “Монголын морин спорт уяачдын	100

			холбоо”, “Монголын мото спортын холбоо”, “Эгэл Монгол” төрийн бус байгууллагуудыг оролцуулан Zangi.mn сайттай хамтран “Төмөр унаа түмнийг хөнөөсөөр” зорилтот нэг удаагийн нэвтрүүлэг, “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” нөлөөллийн аяны хүрээнд ослын хар цэгийг сонгон авч, “Монголын урчуудын эвлэл”-ийн уран бүтээлчидтэй хамтран “Үргэлжилж буй хадаг” сэдвээр 1 видео контентыг тус тус бэлтгэн цахим орчинд иргэд, олон нийтэд түгээж ажилласан.	
22.	Жолооч бэлтгэх сургалтыг чанаржуулах, эрх зүйн орчны судалгаа хийж төсөл бэлтгэж батлуулах. /ГХУСА33-2.1.4/	Жолоочийн мэдлэг, ур чадварт тавигдах шаардлага нэмэгдэнэ.	<p>Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Хууль зүй, дотоод хэргийн яамны Ажлын хэсгийн хуралдаанд цагдаагийн байгууллагыг төлөөлөн Хуулийн хэлтсийн дарга санал, дүгнэлт боловсруулж ажилласан бөгөөд Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2022.05.05-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.</p> <p>Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн Арван дөрөвдүгээр бүлэгт тээвэр, тээврийн хэрэгслийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг зөрчлийг тусгасан.</p> <p>Энэ зүйлд нийт 58 зөрчлийн үйлдэлд шийтгэл оногдуулахаар тусгаснаас 36 хэсэгт заасан зөрчлийн үйлдэлд сануулах, 9 хэсэгт заасан үйлдэлд оногдуулах торгох шийтгэлийн хэмжээ нь дээд, доод хязгаартай байхаар тусгалаа. Өөрөөр хэлбэл, жолооч бүсээ зүүгээгүй байх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй, эсхүл ядарсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, жолооч хот, суурин газраас бусад газар Замын хөдөлгөөний дүрэмд заасан баримт бичиггүй тээврийн хэрэгсэл жолоодсон, улсын бүртгэлийн дугаар нь арилсан, эсхүл бүдгэрч үзэгдэх байдал нь муудсан, эсхүл танигдахгүй бохирдсон, эсхүл дугаарыг буруу байрлуулсан тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон, Замын хөдөлгөөний дүрэмд заасан тээврийн хэрэгслийн дуут дохио өгөх журам зөрчсөн зэрэг үйлдэлд шууд торгох шийтгэл оногдуулж байгааг практик шаардлагад үндэслэн эхний удаа торгохгүйгээр, тухайн зөрчлийн хууль зүйн учир холбогдлыг тайлбарлаж сануулах шийтгэл оногдуулахаар тусгасан байна.</p> <p>Түүнчлэн энэ зүйлийн 31-д заасан зөрчилд жолоочийн замын хөдөлгөөний дүрэмд заасан тээврийн хэрэгслийн хурд хэтрүүлэх зөвшөөрөгдсөн дээд хязгаар 30-50 хүртэл хувь байсныг 10-50 хүртэл хувь гэж өөрчлөн тусгасан.</p>	100
<b>2.2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>				
23.	Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрыг шинээр болон бүсчлэн байгуулах талаар холбогдох судалгаа хийж, шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад хүргүүлэх./ГХУСА33-2.2.1/	Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар шинээр болон бүсчлэн байгуулах талаар холбогдох судалгааг хийж, санал хүргүүлсэн байна.	Монгол улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Л.Нямгэрэлд “Архидан согтуурахтай тэмцэх сан”-гийн хөрөнгөөр 2022 онд хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд эрүүлжүүлэх, саатуулах байрны орчин нөхцөл, үйлчилгээг боловсронгуй болгоход шаардлагатай тоног, төхөөрөмжийн зардлын тооцоо, 165 сая төгрөгний үнийн санал, техникийн үзүүлэлт, танилцуулгыг	90

			<p>2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр 13/95 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Хөвсгөл, Дорнод, Хэнтий, Баянхонгор, Баян-Өлгий, Өмнөговь аймаг дах цагдаагийн газар, хэлтсүүд аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, төрийн болон төрийн бус байгууллагатайгаа хамтран Архидан согтуурахтай тэмцэх дэд хөтөлбөр батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал:</p> <p>Хөвсгөл аймаг дах цагдаагийн газар төрийн 14 байгууллагын 310 алба хаагч, ерөнхий боловсролын 1305 сурагч, 9 аж ахуй нэгжийн 830 ажилчдыг арга хэмжээнд нэгдүүлж, “Архигүй Хөвсгөл” хөтөлбөрийг санаачлан аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч нарын хуралдаанаар хэлэлцүүлэн 2 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр батлуулсан.</p> <p>Баянхонгор аймаг дахь цагдаагийн газраас согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архины хор хөнөөлийг иргэдэд сурталчлах, архины хамаарал бүхий /донтогч/ иргэдэд эмнэлгийн болон нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор “Жаргалтай амьдрал” төвийг байгуулсан.</p> <p>Баянхонгор аймагт архи, согтууруулах ундаанд донтох эмгэгтэй иргэдийг эмчлэх “Жаргалтай амьдрал” сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төвийг үүсгэн байгуулсан тухай төсөл, үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад энэ оны 13-2/819 дугаар албан бичиг, улсын хэмжээнд хэрхэн зохион байгуулах, шинэ санал, санаачлага гарган ажиллах чиглэлээр 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр 13/768 дугаартай албан бичгээр үүрэг, ажлын чиглэл тус тус хүргүүлээд байна.</p>	
24.	Дэмжих бүлгийн гарын авлага боловсруулж, хэвлүүлэх, зорилтот бүлэгт хүртээл болгох. /ГХУСА33-2.2.3/	Гарын авлага хэвлэгдэж, зорилтот бүлэгт хүрсэн байна.	<p>Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн санхүүжилтээр “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнийг таних, илрүүлэх анхаарах асуудал” сэдэв гарын авлагыг 300 ширхэгийг хэвлүүлэн 6 аймаг, 3 цагдаагийн хэлтэс, ШШГГ-ын 3 байгууллагын нийт 1550 алба хаагчдад алба хэрэгцээнд ашиглуулахаар хүлээлгэн өгсөн.</p> <p>Мөн “Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн ойлголт, хууль бус эргэлт”, “Мансууруулах, сэтгэцэд нөлөөт үйлчилгээтэй ургамлын ойлголт, анхаарах асуудал”, “Угтвар бодисын ойлголт” сэдвээр тус тус гарын авлага боловсруулан ажиллаж санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлсэн.</p>	100
25.	Зэрлэг байдлаар ургаж буй мансууруулах үйлчилгээтэй ургамлыг устгах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран тархац тогтоогдсон аймгийн нутаг дэвсгэрт зохион байгуулах. /ГХУСА33-2.2.4/	Устгалын ажлыг зохион байгуулсан байна.	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайд, Байгаль орчин аялал, жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн мн-144/мн-187/мн-22 дугаар тушаалаар батлагдсан “Устгал” нэгдсэн арга хэмжээний удирдамж, төлөвлөгөө, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр баталсан салбар төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, мансууруулах үйлчилгээтэй олсны ургамал (каннабис)-ын тархац тогтоогдсон 11 аймаг болон нийслэл хотын</p>	100

			хэмжээнд зэрлэг байдлаар ургаж буй уг ургамлыг устгах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор тус нэгдсэн арга хэмжээг зохион явуулж улсын хэмжээнд 84,314,280 төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлүүлж 1924.36 га талбайд устгал хийх ажлыг зохион явуулсан.	
26.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллагад шаардлагатай програм хангамж, техник хэрэгсэл, багаж нийлүүлэх. /ГХУСА33-2.2.5/	Шаардлагатай программ хангамж, техник хэрэгсэл, хөрөнгө оруулалт хийгдсэн байна.	Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах” ажлын хүрээнд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 22 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулж худалдан авах ажлыг зохион байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг 3 байгууллагаас үнийн саналыг авч харьцуулсан үнийн судалгаа хийж, хамгийн бага үнийн санал ирүүлсэн, туршлагатай, чанарын өндөр түвшинд нийлүүлэх санал ирүүлсэн “Монтех дистрибьюшн” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр байгуулж, гэрээгээр гүйцэтгэсэн ажлыг 2022 оны 04 дугаар сарын 27-ны өдөр хүлээн авч, гэрээ хүлээлцэх акт үйлдсэн. Алба хаагч нарт 7 төрлийн 15 ширхэг техник, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгч, эд хариуцагчийн бүртгэлд хамруулан өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.	100
<b>2.3. Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>				
27.	Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх. /ГХУСА33-2.3.1/	Үнэлгээ хийж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.	Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр 2021 оны 12 дугаар сараас дууссан.	0
28.	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллах, дэмжлэг үзүүлэх. /ГХУСА33-2.3.2/	Энэ төрлийн хэрэгт өртөж хохирсон иргэдийн зөрчигдсөн эрх ашиг хангагдана.	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон нийт 8 иргэнд сэтгэл зүйн болон, эрүүл мэнд, хууль зүйн туслалцааг төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор зохих журмын дагуу шуурхай үзүүлж байна. Тухайлбал: Тус хэлтсээс шалгаж буй хэргийн насанд хүрээгүй хохирогч нарыг хөндлөнгийн нөлөөлөлд автуулахгүй байх бусад аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар”, “Хүүхэд хамгаалах төвийн хамгаалах байр”, “Хүйсийн тэгш эрхийн төв” ТББ, “Талита Ази” ТББ-уудтай хамтран ажилласан.	100
29.	Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалт зохион байгуулах. /ГХУСА33-2.3.3/	Сургалт зохион байгуулагдаж, үр дүнг тооцсон байна.	Азийн сан олон улсын байгууллагын Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа төслийн хүрээнд “Алба хаагчдыг чадавхжуулах нь” суралцагчийн гарын авлага модуль-7, модуль-8, модуль-9 дээр 1 алба хаагч ажлын хэсэгт орж холбогдох саналыг өгч ажилласан.	100

			<p>Хүн худалдаалах, Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шийдвэрлэлт, хүндрэл бэрхшээл анхаарах асуудал"-ын талаарх хамтарсан зөвлөгөөнд Эрүүгийн цагдаагийн албанаас 2 алба хаагч энэ оны 10 дугаар сарын 28-ны өдөр хамрагдсан.</p> <p>Эрүүгийн цагдаагийн албаны 2022 онд зохион байгуулах ажлын байрны сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөөний хүрээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн ойлголт, үзэл баримтлал. /ЦБҮАЖ код -922 Ялгаварлан гадуурхах, ажлын байрны бэлгийн дарамтаас хамгаалах/ сэдэвт 1 цагийн сургалтыг нийт бие бүрэлдэхүүний дунд зохион байгуулсан.</p> <p>Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Гүйцэтгэх ажлын тэнхимийн хичээлийн сургалтад зориулж, хариуцсан чиглэлийн хүрээнд шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн жишээг РР слайд бэлтгэж Захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн.</p>	
30.	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч иргэдийг зохих сургалтад хамруулж, ажлын байраар хангах чиглэлээр холбогдох арга хэмжээ авах. /ГХУСА33-2.3.4/	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулж, ажлын байраар хангах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна.	Эрүүгийн цагдаагийн албанаас шалгаж буй хэргийн насанд хүрээгүй хохирогч нарыг хөндлөнгийн нөлөөлөлд автуулахгүй байх бусад аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сургалтад хамруулж, ажлын байраар хангахад зуучлах чиглэлээр “Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар”, “Хүүхэд хамгаалах төвийн хамгаалах байр”, “Хүйсийн тэгш эрхийн төв” ТББ, “Талита Ази” ТББ-уудтай хамтран ажилласан.	100
<b>2.4. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх</b>				
31.	“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд салбар хоорондын олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” сэдэвт Үндэсний чуулган зохион байгуулах. /ГХУСА33-2.4.1/	Үндэсний чуулган зохион байгуулагдаж, зөвлөмж гарсан байна.	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан хамтран хэрэгжүүлж буй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” үндэсний чуулганыг Төрийн ордны Их Монгол танхимд хамтарсан багийн 825 гишүүдийг хамруулж, энэ оны 11 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан. <p>Цагдаагийн байгууллагаас Үндэсний чуулганд оролцсон орон нутгийн хамтарсан багийн 428 гишүүдийн албан томилолт, өдрийн хоолны зардалд 174.080.000 төгрөгийг уг төслийн зардлаас шийдвэрлүүлж, оролцогчдод тарааж ажилласан.</p>	100
32.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийлгэх. /ГХУСА33-2.4.2/	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт хангагдаж, хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар дээшилнэ.	Олон Улсын эрх зүйн байгууллага “IDLO”-ийн дэмжлэгтэйгээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийлгэх байгууллагын сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулж, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх иргэн, байгууллага сонгон шалгаруулах тендерийг 2 удаа зарласан боловч шаардлага хангасан байгууллага материалаа ирүүлээгүй байгаа тул дахин тендерийг зарлахаар ажиллаж байна.	30



33.	Хамтарсан багийн гишүүдийн ажил үүргийн жишиг хуваарийн төсөл боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлж, батлуулах. /ГХУСА33-2.4.3/	Хамтарсан багийн гишүүдийн ажил үүргийн жишиг хуваарийн төсөлд санал боловсруулан хүргүүлсэн байна.	Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас хамтарсан багийн гишүүдийн ажлын байрны тодорхойлолтод хийсэн дүн шинжилгээний тайлангийн хэлэлцүүлэг зохион байгуулах үед цагдаагийн байгууллагаас 7 алба хаагч оролцсон. Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас хамтарсан багийн гишүүдийн ажил үүргийн жишиг хуваарийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулаагүй байна.	30
-----	--	---	--	----

**2.5. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх**

34.	Хилийн зурвас, бүсэд үйлдэгдэх гэмт хэрэг, хил орчмын дэглэмийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль сахиулах байгууллагууд болон орон нутгийн засаг захиргаатай хамтран Увс, Сэлэнгэ, Хэнтий аймгийн хилийн хэсэгт хилийн хамтарсан ажиллагаа явуулж, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах. /ГХУСА33-2.5.1/	Хилийн тухай шинэчилсэн найруулгын хуулийн 35 дугаар зүйлийн хэрэгжилт хангагдана.	Монгол Улс, ОХУ-ын цагдаагийн болон дотоод хэргийн хил орчмын бүс нутгийн нэгжүүд хоорондоо төв байгууллагуудаараа дамжуулан Дорнод аймгийн цагдаагийн газар Оросын Холбооны Улсын Өвөрбайгалийн хязгаар дахь Дотоод хэргийн удирдах газартай энэ оны 02 дугаар сарын 28, 06 дугаар сарын 27, 10 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаарын Чита хотын цагдаагийн газартай Агийн Бурятын тойрогт, Увс аймгийн цагдаагийн газар Оросын Холбооны Улсын Тува Улс дахь Дотоод хэргийн яамтай цахим уулзалт, зөвлөгөөн зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2000 оны хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Баян-Өлгий аймгийн цагдаагийн газраас Хилийн цэргийн 0285 дугаар ангитай хамтран хилийн бүсийн сумуудын “Хулгайлагдсан болон бэлчээрээр улсын хил давсан малыг эрэн сурвалжлах, буцаан өгөх комисс”-ын хамтарсан сургалтыг Цагааннуур сумын төв, Улаанбайшинтын боомт, хилийн бүс газарт 2022 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Улаанхус, Цагааннуур тосгон, Ногооннуур сумын Засаг дарга, Тамгын газрын дарга, багийн Засаг дарга, малын эмч нарыг оролцуулан онолын мэдлэг олгох, бүлгээрээ ажиллах, практик дадлага сургууллт гэсэн 3 үе шатаар зохион байгуулсан. Хамтын ажиллагааны үр дүнд 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Увс аймгийн Бөхмөрөн сумын нэгдүгээр багийн Улаан хад гэх газарт бэлчээрлэж байсан иргэн С.Гантулгын 26 тооны адуу, Б.Даваасүрэнгийн 18 тооны адуу энэ оны 03 дугаар сарын 21-22-ны шилжих шөнө хулгайлагдаж, Оросын Холбооны Улсын Тува Улсын хилээр нэвтэрсэн адуунаас 40 тооны адууг олж тогтоон, Дорнод аймгийн Баяндун сумын 1 дүгээр багийн нутаг “Шавардаашийн булаг” гэх газраас 2022 оны 04 дүгээр сарын 15-16-ны шилжих шөнө иргэн Ш.Ялалтын 74 тооны адуу бэлчээрээс алдагдаж, Оросын Холбооны Улсын Өвөрбайгалийн хязгаарын нутгаар хил нэвтэрсэн адуунаас 21 тооны адууг олж тогтоон, хохирогчид тус тус хүлээлгэж өгсөн. Увс аймгийн цагдаагийн газраас хил орчмын бүсийн бод малын хөдөлгөөнийг хянах зорилгоор Их Британи Улсад үйлдвэрлэсэн байршил тогтоогч “GPS” төхөөрөмжийг “Шинэ зууны адуучин” ХХК-тай хамтран тус аймгийн Сагил, Давст сумын хил орчмын бүсэд нутагладаг малчин өрхүүдийн адуунд байршуулах ажлыг зохион байгуулж 28 ширхгийг тухайн малчдын азарга, Тухайн “GPS” 800.000 төгрөгийн үнэтэй ба сарын	100
-----	--	--	---	-----

			суурь хураамж 44.000 төгрөг, 3 сараар сунгасан тохиолдолд 36.000 төгрөгийн өртөгтэй ба хилийн бүсийн бусад аймгуудад нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	
35.	Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах. /ГХУСА33-2.5.2/	Мэргэжлийн байгууллагаас заавар, зөвлөмж хүлээн авч хэрэгжүүлсэн байна.	Нийслэлийн байгаль орчны газартай хамтран нийслэлийн ногоон бүсийн 12 байгаль хамгаалагч, 30 иргэнд байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулсан. Нийслэлийн байгаль орчны газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа зэрэг байгууллагуудтай хамтран “Самар-2022” хэсэгчилсэн арга хэмжээг энэ оны 09 дүгээр сарын 05-наас 15-ны өдрийн хооронд Баянзүрх дүүргийн 11, 14, 20 дугаар хороонуудын нутаг дэвсгэрт байрлах Манзуширын ам, Баянголын ам, Хуайндайгийн ам, Сүхбаатар дүүргийн 19, 20 дугаар хороонуудын нутаг дэвсгэрт байрлах Бэлх, Гүнжийн, Хандгайт, Их Бага баяны ам, Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Богдхан уулын Түргэний ам, Жаргалантын ам, Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо Зүрх уулын ам зэрэг ногоон бүсүүдэд нийт 32 удаагийн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 120 отог, 673 иргэнийг уулнаас буулгаж, 89 шуудай цайруулсан самар, 104 шуудай боргоцойг хураан авч, зөрчлийн шинжтэй 20 үйлдлийг илрүүлж, иргэдэд Ойн тухай хууль тогтоомж зөрчих зөрчлөөс урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, уулнаас буулгах, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан.	90
36.	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд “Байгалиа хамгаалъя” олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулах. /ГХУСА33-2.5.3/	Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар иргэдийн мэдлэг, ойлголт дээшилж, урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоо нэмэгдсэн байна.	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх энэ төрлийн гэмт хэргийн хор уршгийг иргэд, олон нийтэд таниулах, тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг “Ногоон дуу хоолой” нэрийн доор энэ оны 04 сарын 15-ны өдрөөс 05 сарын 15-ны өдрийн хооронд орон даяар “Зөв мод-Зөв арчилгаа” уриатайгаар Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран зохион байгууллаа. Дээрх аяны хүрээнд мод тарьж ургуулахтай холбоотой технологийн заавар, зөвлөмж бүхий шинжлэх ухаан, танин мэдэхүйн үндсэн видео шторк 10, зурагт постер 18 тус тус бэлтгэж, иргэд олон нийтэд сурталчилсныг 114.462 хүн дэмжиж, 12.509 хүн эерэг сэтгэгдэл үлдээж, 130.154 хүн бусдад түгээсэн нь давхардсан тоогоор 14.265.656 хүнд хүрч иргэдийг мод тарихад уриалсан, мод тарих, ургуулах соёлыг дэлгэрүүлсэн, хандлага мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн, буруу дадал хандлагад эергээр нөлөөлсөн, зөв үйлдэлд уриалж сэдэлжүүлсэн арга хэмжээ болсон. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд энэ оны 05 дугаар сарын 01-нээс 30-ны өдөр, 10 дугаар сарын 03-ны өдрөөс 15-ны өдөр хүртэлх хугацаанд “Байгалиа бүтээе” нөлөөллийн аяныг 2 удаа тус тус зохион байгуулж, Эх дэлхий, байгаль орчноо хайрлан хамгаалж зохицон амьдрах, дэлхийн уур	100

			амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилго бүхий шинжлэх ухаан, танин мэдэхүйн чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран хавар, намрын мод тарих ургуулах зөвлөгөө зөвлөмж 4, иргэдийг мод тарихад уриалан бэлтгэсэн 62 видео шторк, сайтын сурвалжлага-5, нийтлэл-4, 52 зурагт постер, контентуудыг давхардсан тоогоор орон сууцны 1830 лифт, орон нутаг нийслэлийн 30, иргэн аж ахуйн нэгжийн эзэмшлийн 62, худалдаа үзвэр үйлчилгээний 122, нийт 214 сурталчилгааны лед самбаруудад байршуулж, төв орон нутгийн 44 телевизээр 3357 удаа 420.913 секунд хугацаагаар иргэд, олон нийтэд хүргэж, зорилтод мэдээллийг 43 фм радиогоор 38 өдрийн турш түгээж ажиллаж, цахим орчинд байршуулж түгээснийг 523.836 хүн дэмжиж, 728.271 хүн эерэг сэтгэгдэл үлдээж, 3.318.777 хүн бусдад түгээсэн ба давхардсан тоогоор 40.547.100 хүнд хүрсэн байна.	
<b>2.6. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>				
37.	Мал аж ахуйн нэгдсэн системд малын бүртгэлийн дэд сангуудыг нэгтгэх ажлыг эрчимжүүлж, зохион байгуулах. /ГХУСА33-2.6.1/	Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд шинэчлэлт хийсэн байна.	"Малчин лавлах-109" тусгай дугаарт ирсэн алдсан, олдсон малын зарыг цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах "ASAP" санд холбосон. Үүний үр дүнд цагдаагийн алба хаагч нар алдсан, олдсон малын зартай түргэн шуурхай танилцах боломжоор хангагдсан. Мөн цахим гарал үүслийн гэрчилгээний сан <a href="https://vet.certificate.mn/">https://vet.certificate.mn/</a> - ны мэдээллийг 2021 онд цагдаагийн байгууллагын "нэгдсэн хайлт" системд холбосноор цахим гарал үүслийн гэрчилгээнд цагдаагийн байгууллагаас тавих хяналтыг сайжруулсан. Энэ ажлын хүрээнд тус системийг илүү боловсронгуй болгож, хөгжүүлэлтийн ажлыг хийж дуусгасан.	100
38.	Алдсан, олдсон малыг түр харгалзах газар /хашаа/-тай болгох асуудлыг судалж, шийдвэрлэх. /ГХУСА33-2.6.2/	Алдсан, олдсон малыг түр харгалзах газартай болсон байна.	Алдсан, олдсон малыг түр харгалзах хашааны газрыг Нийслэлийн газар, зохион байгуулалтын албанаас 2022 оны 05 дугаар сарын 22-ны өдөр 0000067581 дугаартай газар эзэмших гэрчилгээг гаргуулан авч шийдвэрлүүлсэн. Тухайн газарт чанарын шаардлага хангасан бетонон хашаа барих, худаг гаргуулахаар үнийн судалгаа хийж "Ситимент" ХХК, "Титэм хийц" ХХК, "Сан индустриал" ХХК-уудаас үнийн саналыг авсан. "Сан индустриал" ХХК нь хамгийн доод үнийн санал буюу 50,626,000 /тавин сая зургаан зуун хорин зургаан мянга/-н төгрөгийг үнийн дүн ирүүлснийг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж, даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний үр дүнд Санхүү, аж ахуйн албанд төсвийг шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн. Одоогоор алдсан, олдсон малыг түр харгалзах хашааны санхүүг Цагдаагийн ерөнхий газраас шийдвэрлээгүй байна.	100
<b>2.7. Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>				
39.	Согтуурах, мансуурах донтой хүний албадан болон сайн дурын эмчилгээний үр дүнг дээшлүүлэх, нийгэмшүүлэх хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх. /ГХУСА33-2.7.1/	Хөтөлбөрт 150-аас доошгүй согтуурах, мансуурах донтой хүнийг хамруулсан байна.	Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар 37 эрүүлжүүлэх, саатуулах байр үйл ажиллагаагаа явуулж байна. /Нийслэлд 9, 21 аймагт тус бүр 1, сум дундын цагдаагийн хэлтэст 7/ Үүнээс тусдаа байртай 19, цагдаагийн газар, хэлтсийн байранд 18 /үүнээс байрны хонгилд 10/ тус тус ашиглаж байна.	90

			Нийслэлийн Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтэс, Завхан аймаг дахь цагдаагийн газрын Тосонцэнгэл сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх саатуулах байрууд 100 хувь стандарт, шаардлага хангасан байртай байна.	
40.	Архисах өвчтэй хүний асуудлыг дэмжих, тусламж үйлчилгээ үзүүлэх, эмчлэх тусгайлсан асрамжийн газрыг байгуулах ажлыг эхлүүлэх. /ГХУСА33-2.7.2/	Тусламж үйлчилгээ үзүүлэх, эмчлэх тусгайлсан асрамжийн газар байгуулах санал танилцуулга хүргүүлж, санхүүжилтийг шийдвэрлүүлсэн байна.	Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас 2022 онд тэргүүлэх 5 чиглэлд “Архидан согтуурахтай тэмцэх” ажил, арга хэмжээг эрчимжүүлэх” зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан 2020 оны А/580, А/228 дугаар тушаалын дагуу Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Нийслэлийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Сонгинохайрхан дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохилцуулах салбар зөвлөлөөс “Хорт зуршилгүй залуу” төслийн хүрээнд Архины сайн дурын эмчилгээг Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороонд үйл ажиллагаа явуулдаг “Цагаан өргөө” сувиллын газарт зохион явуулж 3 сарын хугацаад 100 иргэнийг хамруулах ажлыг зохион байгуулсан. Улсын хэмжээнд архидан согтуурахтай тэмцэх нийт 13 хөтөлбөр хэрэгжиж байгаагаас орон нутагт Баяхонгор, Баян-Өлгий,Өвөрхангай, Өмнөговь, Дорнод,Төв, аймгууд, Нийслэлд Баянгол,Хан-уул, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргүүд тус тус тухайн аймаг, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газраас нийт 372,9 сая төгрөгийн төсвийг шийдвэрлүүлэн ажиллаж байна.	70
41.	Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрүүлжүүлэх, баривчлах байрны орчин, үйлчилгээг боловсронгуй болгоход шаардагдах тоног төхөөрөмжөөр хангах. /ГХУСА33-2.7.3/	Шаардагдах тоног төхөөрөмжөөр хангаж, эмчилгээ, сургалт, үйлчилгээний чанар дээшилсэн байна.	Архангай, Хэнтий, Булган, Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн газар, хэлтсүүд 2022 оны эхний улиралын байдлаар эрүүлжүүлэх, саатуулах байранд 48.000.000 төгрөгний засвар үйлчилгээг хийсэн байна. Энэ оны эхний 11 сарын байдлаар Нийслэлийн эрүүлжүүлэх саатуулах төвийн байранд 96.0 сая төгрөгийн их засварын ажиллагаа хийж, “Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ, ерөнхий шаардлага” MNS 5527-2019 стандартад нийцүүлсэн. Монгол Улсын Их Хурлаас баталсан цагдаагийн байгууллагын 2022 оны төсөвт Архангай аймаг дахь цагдаагийн газрын барилгын /Эрүүлжүүлэх, саатуулах байртай/ 1,2 тэрбум төсөв батлагдаж, Архангай аймгийн засаг даргын тамгын газраас барилга бариулах газрын асуудлыг шийдвэрлэж, барилгын зураг төслийг “ББСМО” ХХК-аар архитекторын шийдэл судалгааг гаргуулан нийт 5.4 тэрбум төгрөгөөр Цагдаагийн газрын албан контор, түр саатуулах байрны 2 блокийг 2022 онд бариулахаар төлөвлөн тендерийг зарлуулан ажиллаж байна. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабарын дагуу 2023 оны төсвийн хязгаарын санал, төсвийн төсөлд тусгуулахаар Булган, Говьсүмбэр, Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газруудад шинээр эрүүлжүүлэх, саатуулах байр барих зураг төслийг гүйцэтгүүлэн бэлэн болгож баталгаажуулсан, Баянхонгор аймаг дахь цагдаагийн газрын	100

			<p>эрүүлжүүлэх байрны засварын саналыг хүргүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.</p> <p>Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 7 дахь зорилгын 7.1.3 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 02/10 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.3.3.3 дахь заалтад “Эрүүлжүүлэх, саатуулах байруудын нөхцөлийг сайжруулах, нийслэлийн хэмжээнд нэгдсэн эрүүлжүүлэх, саатуулах байр барих бэлтгэл ажлыг хангах” зэргээр тусгагдсан байдаг.</p> <p>Энэ чиглэлээр Нийслэлийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, Улаанбаатар хотын баруун, зүүн бүсэд нэгдсэн эрүүлжүүлэх, саатуулах байр барих дэд бүтэц, шугам сүлжээ бүхий газрын асуудлыг судлаж, шийдүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Эрүүлжүүлэх, саатуулах байрны ажиллагсад, үйлчлүүлэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ухуулга, сургалт, нөлөөллийн ажлыг тухай орчин нөхцөлд нь явуулахтай холбогдуулан 37 эрүүлжүүлэх, саатуулах байранд 167.960.000 төгрөгийн тоног төхөөрөмж бүхий иж бүрэн компьютер, принтер, проектор, проекторын дэлгэц, гар хатаагч зэргийг худалдан авах зайлшгүй хэрэгцээ шаардлага байна гэж үзэж Монгол улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд Архидан согтуурахтай тэмцэх сангийн хөрөнгөөр 2022 онд хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд эрүүлжүүлэх, саатуулах байрны орчин нөхцөл, үйлчилгээг боловсронгуй болгоход шаардлагатай тоног, төхөөрөмжийн зардлын тооцоо, үнийн санал, техникийн үзүүлэлт, танилцуулгыг энэ оны Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны даргын 13/95 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p>	
42.	<p>Эрүүлжүүлэх, баривчлах байрны үйлчлүүлэгчдэд (баривчлагдсан этгээд) хууль эрх зүйн мэдлэг олгох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт явуулах. /ГХУСА33-2.7.4/</p>	<p>Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдаж, хэрэгцээтэй мэдээлэл, сургалт орсон байна.</p>	<p>Улсын хэмжээнд энэ оны эхний 5 сарын байдлаар 31966 иргэн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3455 нэгжээр буюу 12,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Улсын хэмжээнд тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймаг, дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсүүдээс ерөнхий 11, тусгай 445, соён гэгээрүүлэх 154, нийт 610 арга хэмжээг зохион байгуулж, сургалт 2977, уулзалт, хэлэлцүүлэг, ярилцлага 207, өдөрлөг 84 удаа зохион байгуулж, 5938 аж ахуйн нэгж, байгууллагын 95419 иргэдийг хамруулсан байна.</p> <p>Архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллагад 9756 мэдэгдэл, 1009 шаардлага өгч биелэлтийг шалгаж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлээгүй 239 иргэн, 93 хуулийн этгээдэд 242, 650,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан.</p>	100

			<p>Мөн Орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэдийг шинэ Коронавирусийн /ковид-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Нийслэл хотод орон гэргүй тэнэмэл байдлаар амьдардаг иргэдийг болзошгүй эрсдэлээс хамгаалах, нийгэмшүүлэх “Тэнэмэл” тусгай арга хэмжээг энэ оны 02, 03 дугаар сард 2 удаа зохион байгуулж, нийт 209 хүнийг олж тогтоон, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулснаас 13 иргэнийг ар гэрт нь, коронавируст халдвар /ковид-19/-ын эерэг хариу гарсан 1 иргэнийг “Энэрэл” эмнэлэгт, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх “Нийгмийн хамгааллын тусгай төв”, “Өлзийт асар”, “Титэм констракшин”, “Дөлгөөн минж”, “Шинэ амьдрал ялагч” зэрэг 5 төрийн болон төрийн бус байгууллагуудад 195 иргэнийг тус тус хүлээлгэн өгч ажилласан.</p> <p>Төмөр зам дахь цагдаагийн газраас албадан эрүүлжүүлэх байранд эрүүлжүүлэгдсэн нийт 1063 эмэгтэйд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хэрхэн хаана хандах, мөн хүүхдийн эсрэг хүчирхийллийн чиглэлээр яриа таниулга хийж, тусламжийн хуудас 620 ширхэгийг тарааж ажилласан. Аймаг нийслэлийн насан туршийн боловсролын төвтэй хамтран 60 хүүхдэд суурь боловсрол олгох сургалт явуулсан байна.</p>	
43.	Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулах.	Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийг тодорхой хувиар бууруулна.	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран иргэд, олон нийтийг согтууруулах ундааны хорт зуршил, буруу хэрэглээнээс татгалзуулах, түүнээс үүдэн гарах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор энэ оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд “Намайг алгас” нөлөөллийн аяныг зохион байгуулж бэлтгэл ажлын хүрээнд аяны брэндиг, стратегийг боловсруулж, олон нийтийн дундах архины өргөн хэрэглээг бууруулах, зохисгүй хэрэглээг бууруулах, зөв хандлага, сонголт, шинэ соёлыг төлөвшүүлэх, дэмжихэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны 28 ажил, арга хэмжээг төлөвлөн, зохион байгуулж үндсэн 88 видео шторк, 36 зурагт постерыг мэргэжлийн байгууллагуудаар бүтээлгэн, Ажлын хэсгээс 54 дэмжих видеог бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан. Бэлтгэсэн видео контент, мэдээ, мэдээллүүдийг төв, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг иргэн, хуулийн этгээдийн 130, худалдаа, үзвэр үйлчилгээний 214, нийт 344 сурталчилгааны лед дэлгэцээр нийтийн орон сууцны 900 лифт, 42 телевиз, 30 фм радиогоор тус тус түгээж, автобусны буудал болон автозам дагуу 143, бусад байршилд 38, нийт 181 мэдээллийн самбарт “Намайг алгас” сурталчилгаа, мэдээллийн постерыг байршуулсан. Иргэдийг соён гэгээрүүлэх, идэвхжүүлэх зорилгоор уулзалт, өдөрлөг, сургалт, хэлэлцүүлгийг давхардсан тоогоор 609 удаа зохион байгуулж, арга хэмжээний үндсэн агуулгыг таниулсан тараах материалыг 30.000 ширхэг хэвлэн төв, орон нутгийн худалгаа үйлчилгээний газар болон иргэд олноор цугладаг цэгүүдэд тараасан.</p> <p>Хамт олон, найз нөхдийн дундах архидалт, тэмдэглэлт өдрүүдийн архи согтууруулах ундааны хэт их хэрэглээг шүүмжилсэн, буруу үзэгдэл үйл явдлаас залуу үеийг татгалзуулж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх,</p>	100

			<p>хосууд гэр бүлдээ цаг зарцуулахад уриалсан 2 дууг бүтээн иргэд, олон нийтийн хүртээл болгосон.</p> <p>“Юнивишн”, “ДДИШ” телевизийн 400.000 хэрэглэгч айл, өрхөд “Намайг алгас” аяны сурталчилгааны баннер, “Скайтел”, “Жи Мобайль” үүрэн холбооны 1.475.251 хэрэглэгчийн дуудлагын аянд зохисгүй хэрэглээнээс татгалзах уриалга бүхий шторкийг байршуулах боломжийг бүрдүүлж, хамтран ажилласан.</p> <p>Уг аяныг сурталчлах өдөрлөгийг улсын томоохон их, дээд сургуулийн төлөөлөл 1200 гаруй оюутан, залуусыг хамруулан энэ оны 11 дүгээр сарын 30-ны өдөр “ЮЖ Арина” цогцолборт зохион байгуулж, хэвлэл, мэдээллийн 23 телевиз, сайтаар иргэд, олон нийтэд түгээсэн.</p> <p>Ухуулга, нөлөөллийн арга хэмжээний үр дүнд гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт дуудлага мэдээлэл өмнөх сарын мөн үетэй харьцуулахад 1044, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчил гаргасан гэх дуудлага мэдээлэл 337 нэгжээр тус тус буурсан эерэг үзүүлэлт гарсан. Мэдээлэл, сурталчилгааны ажлын хүрээнд нийт 188 мэдээлэл бэлтгэн цахим орчинд түгээсэн нь давхардсан тоогоор 1.437.228 хүнд таалагдаж, 4.326.623 хүн бусадтай хуваалцаж, 402.332 хүн эерэг сэтгэгдэл илэрхийлж, 67.060.623 хүнд хүрсэн байна.</p> <p>Мөн иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, архины зохисгүй хэрэглээг багасгах, тэднийг зөв үйлдэлд уриалах, согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Зөвийг зөвлөө” арга хэмжээг 2022 оны 03 дугаар сарын 03-наас 24-ний өдрийн хооронд улсын хэмжээнд зохион байгуулж 9 их, дээд сургууль, 26 телевиз, радио, сайт, сонин зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, 3 спортын холбоо, 6 төрийн байгууллага, нийт 46 төрийн болон төрийн бус байгууллагын 74600 ажилтан, алба хаагч, 66 олны танил эрхмийг аянд нэгдүүлж, 21 аймаг, 9 дүүрэг, 8106 алба хаагч, 14585 иргэний цахим хуудасны ковер зургийг солиулж, давхардсан тоогоор 1277 видео шторк, 2748 постер, нийт 4025 контентийг бэлтгэн Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, дүүрэг, орон нутгийн цахим хуудсанд байршуулсан нь 6,928,119 хүнд хүрч, 643,890 хүнд таалагдаж, 2,566,609 удаа бусадтай хуваалцсан байна.</p>	
<b>2.8. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр</b>				
44.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд инноваци нэвтрүүлэх, цахим технологи ашиглах хөгжүүлэлтийг нэмэгдүүлэх. /ГХУСАЗЗ-2.8.2/	Судалгаа хийж, санал, зөвлөмж хүргүүлсэн байх.	Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын мэдээллийн аюулгүй байдал, технологийн үйл ажиллагаанд шаардлагатай программ хангамж, техник тоног төхөөрөмжийн судалгаа, 2021 оны 11 дүгээр сард ЦЕГ-ын төсвийн хөрнөгөөс 821 сая төгрөгийн зардлыг шийдвэрлүүлж, тендерт зарласан “Вертексмон” “Тодика”, Ай-ти-Зон ХХК-иас 762,1 сая төгрөгний үнэ бүхий Checkpoint 6000 техник, тоног төхөөрөмж /багц1/, Firewall лиценз /багц3/, 57,1 сая төгрөгний үнэ бүхий техник хэрэгсэлийг тус тус бэлтгэн	70

		<p>нийлүүлсэнийг хүлээн авч, тоног төхөөрөмж, программ хангамжийг суурилуулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.</p> <p>Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд дараах програм хангамжуудыг боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэв. Үүнд:</p> <p>-ЦЕГ-ын санхүүжилтээр цахим архив, албан хэрэг хөтлөлтийн “eArchive, eDOC” програм хангамжийг шинээр худалдан авч, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд</p> <p>Хоногийн мэдээ”, зарлан мэдээлэл дамжуулах “ECS notification”, гар утасны “Police SOP” програм хангамжийг тус тус боловсруулж энэ оны 02 дугаар сарын 01-ний өдрийн №2 дугаартай “Программ хангамж хүлээлцэх акт”-аар Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Мөрдөн шалгах газарт хүлээлгэн өгсөн.</p> <p>Дээрх програм хангамжуудыг 2022.02.01-ний өдөр НЦУГ-ын МШГ-т хүлээлгэн өгснөөс хойш 5 дугаар сарыг хүртэлх 3 сарын хугацаанд хэн болох нь тогтоогдоогүй цогцос 2, Эрэн сурвалжлалтын Асап санд бүртгэгдсэн оргодол 1, гэрээсээ гараад сураггүй алга болсон 2, дээрэмдэх гэмт хэрэг үйлдсэн 2, хулгайлах гэмт хэрэг үйлдсэн 1 этгээдүүдийг олж тогтоосон үр дүнтэй ажиллаж байна.</p> <p>Цагдаагийн Ерөнхий газрын даргын энэ оны А/28 дугаар тушаалаар байгуулагдсан “Цагдаагийн байгууллагын жолоодох эрхийн үйл ажиллагааг мэдээллийн технологийн давуу талыг ашиглаж боловсронгуй болгох, ашиглагдаж байгаа программ хангамж, мэдээллийн санг шинээр боловсруулах, шинэчлэх, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангуулах, үйл ажиллагаанд нэвтрүүлэх” үүрэг бүхий ажлын хэсгээс Бүртгэл хяналтын төвийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа Авто сургуулийн бүртгэл, жолоочийн шалгалт авах программ хангамжид нэмэлт хөгжүүлэлт хийж, туршилтын журмаар ашиглаж байгаа ба жолоочийн мэдээллийн санд нэмэлт хөгжүүлэлтийг хийж байна.</p> <p>Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн сан болон Америкийн Нэгдсэн Улсын сураггүй алга болсон болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдэд туслах Олон Улсын төв (ICMEC) байгууллагын үйл ажиллагаанд ашигладаг CyberTip систем рүү шууд хандах эрхийг авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p> <p>Фэйсбүүк олон нийтийн сүлжээ ашиглан Монгол улсын иргэдийг залилсан гэмт хэргийн талаарх мэдээлэл, судалгааг МБА-ны Залилах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс гаргуулан, хохирлын хэмжээ өндөр хэргүүдийг түүвэрлэн англи хэл рүү орчуулж энэ оны 03 дугаар сарын 22-ны өдөр Мета компанид хүргүүлсэн.</p> <p>Залилах гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд фэйсбүүк компанитай хамтран ажиллах ажлын хэсэгт 2 алба хаагч ажиллаж Фэйсбүүк компаний Ази номхон далайн бүс хариуцсан ажилтан Майклтай харилцах цахим шуудангийн орчуулгыг тогтмол хийсэн.</p>
--	--	--



45.	Цахим хэрэглээний донтолт, түүний хор уршиг, цахим халдлагаас хамгаалах болон хүүхдийн насны онцлогт тохирсон цахим хэрэглээг хяналттай, хязгаартай байдлаар нэвтрүүлэх, бодлогыг боловсролын бүх шатанд хэрэгжүүлэх. /ГХУСА33-2.8.3/	Бодлогын хэрэгжилт хангагдаж, үр дүнд хүрсэн байна.	<p>Хүн амд цахим орчны зүй зохистой хэрэглээний талаар мэдлэг, мэдээлэл олгох, ёс зүйтэй хэрэглээг төлөвшүүлэх, цахим орчинд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Харилцааны холбооны зохицуулах хороотой хамтран “Цахим соёл” арга хэмжээг зохион байгуулж, хүүхэд, иргэд, олон нийтэд Монгол HD, “TV8”, “MYOHT”, “ТВ6”, “С-1”, “Neguun”, “Tsahiur.mn”, “Mass.mn”, “Tug.mn”, “Zarig.mn”, “Toim.mn”, “TV6 mongolia” зэрэг сайт, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээ, мэдээлэл өгч, түгээж ажилласан.</p> <p>Монгол Улсын Засгийн газар болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн 2017-2022 оны улс орны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Олон Улсын сураггүй алга болсон болон мөлжлөгт өртсөн хүүхдүүдэд туслах төв /СМЕС/-тэй хамтран 2022 оны 01 дүгээр сарын 10-наас 12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Цахим орчин дахь хүүхдийн бэлгийн мөлжлөгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга зүй” сэдэвт сургалтад тус хэлтсээс “Цахим орчинд үйлдэгдсэн хүүхдийн эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудал” сэдвээр илтгэл мэдээлэл тавьж, тус сургалтад 15 алба хаагчийг хамруулсан.</p> <p>Нийслэлийн хэмжээнд цахим орчинд садар самуун сурталчлах, видео чат, дуудлагаар биеэ үнэлэдэг, мөн бэлгийн мөлжлөгт өртөж байгаа охид, эмэгтэйчүүдийг олж тогтоох, бүртгэл судалгаанд авах, биеэ үнэлэхийг зохион байгуулдаг этгээдүүдийн хууль бус үйлдлийг илрүүлэх зорилгоор “Шалгалт” тусгай арга хэмжээг энэ оны 09 дүгээр сард зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд 10 газрын судалгааг гарган сэжигтэй 8 объектод шалгалт хийж, дээрх газраас илэрсэн гэмт хэргийн шинжтэй үйлдэлд хэрэг үүсгэн, эрүүгийн 2 хэрэгт яллах дүгнэлт үйлдэж прокурорт шилжүүлэн, хэрэг бүртгэлтийн 6 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.</p>	100
<b>Гурав: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн чиглэлийн хүрээнд:</b>				
46.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд авто зам, замын байгууламжийн стандарт, шаардлага, технологийн горимд тавих хяналт, хариуцлага, түүний үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээ авах. /ГХУСА33-3.1/	Авто зам, замын байгууламжаас шалтгаалсан зам тээврийн осол болох эрсдэлт байдал буурна.	<p>Нийслэл болон хөдөө орон нутгийн авто замын аюулгүй байдлыг хангуулах чиглэлд тээврийн цагдаагийн албанаас 2022 онд нийт 5 чиглэлийн авто зам, замын байгууламж, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл, тэмдэг, тэмдэглэлийн бүрэн бүтэн байдалд холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтарсан үзлэг шалгалтыг зохион байгуулсан болно. Тухайлбал:</p> <p>-Зам, тээврийн хөгжлийн яам, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын албатай хамтран “Улаанбаатар-Сэлэнгэ аймаг” чиглэлийн олон улсын чанартай АНЗ дугаартай авто зам, мөн “Улаанбаатар-Дундговь-Өмнөговь аймаг” чиглэлийн олон улсын чанартай А0201, А0202 дугаартай авто замуудад үзлэг шалгалтыг явуулж, илэрсэн зөрчил дутагдлын талаар тухайн аймгуудын Засаг дарга нарт 14/1141 дугаар албан бичгээр зөрчил арилгах зөвлөмж, ажлын чиглэлийг;</p> <p>-Мөн “Улаанбаатар-Дархан-Уул аймаг” чиглэлийн 204.1 км авто замыг түр хугацаагаар нээхтэй холбогдуулан тус авто замд байрлуулсан замын хөдөлгөөн зохицуулах тэмдэг, хашилт, чиглүүлэх хэрэгслүүд стандартын шаардлага хангаж буй эсэхэд үзлэг шалгалтыг явуулж, тухайн авто замд шинээр зайлшгүй байршуулах шаардлагатай 190 ширхэг тэмдгийн</p>	100

			<p>судалгааг гаргаж Зам, тээврийн хөгжлийн дэд сайдад 11/2598, 11/2790 дугаартай албан бичиг, гүйцэтгэгч байгууллагуудад 11-1/1566, 11-1/1567, 11-1/1568, 11-1/1569 дугаартай албан бичгүүдээр зөвлөмжийг;</p> <p>-“Улаанбаатар-Дархан-Сэлэнгэ-Алтанбулаг” чиглэлийн авто замд үзлэг шалгалтыг явуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар тус аймгуудын Замын цагдаагийн нэгжийн дарга нарт 11-16/1621, 11-16/1622 дугаартай албан бичгүүдээр илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмж, ажлын чиглэлийг тус тус хүргүүлж ажилласан.</p> <p>Түүнчлэн Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байрлах замын хөдөлгөөн зохицуулах тэмдэг, тэмдэглэлийн тооллогыг энэ оны 04 болон 10 дугаар саруудад Нийслэлийн замын хөгжлийн газартай хамтран зохион байгуулж, замын арчлалт хариуцсан байгууллагаар энэ онд нийт 10425.4 м2 “Явган хүний гарц” хэвтээ тэмдэглэлийг нөхөн сэргээх, 346 ширхэг тэмдгийг шинээр суурилуулах, зөрчилтэй 1011 тэмдгийг тэгшлэх, шаардлагагүй 350 тэмдгийг хурааж авах, 182 тэмдгийг шилжүүлж байрлуулах, 185 ширхэг тэмдгийг түр тавих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгүүлэх хяналт тавьж ажилласан байна.</p>	
47.	Ой, ан, байгалийн ургамлын ашиглалт, хамгаалалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт, шалгалт хийх. /ГХУСАЗЗ-3.2/	Улсын хэмжээнд 1-ээс доошгүй нэгдсэн шалгалт хийгдсэн байна.	<p>Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Тарвага-2022”, “Эрчимжүүлэлт-2022”, “Эрэлч нохой-2”, “Усны сан бүхий газар-2022”, “Төр хурахын ам-2022”, “Самар-2022”, “Эрэлч нохой-3” хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, биелэлт үр дүнг тооцсон. Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар бүлэгт заасан байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр “Эко-2022” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж гэмт хэргийн шинжтэй 2 үйлдэл, 37 зөрчил илрүүлсэн.</p>	90
48.	Гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлж суллагдсан хүнд хяналт тавих тогтолцоо, зохион байгуулалтыг боловсронгуй болгох. /ГХУСАЗЗ-3.3/	1-ээс доошгүй оновчтой шийдлийг хэрэгжүүлсэн байна.	<p>Цагдаагийн байгууллагаас улсын хэмжээнд шүүхээс тэнсэн суллагдсан 326, хорих ялаас тэнсэн суллагдсан 193, Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 2, жирэмсэн, 3 хүртэлх настай хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 2, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн 10, хорих ял эдлээд суллагдсан 189 нийт 722 хүнд өнөөдрийн байдлаар хяналт тогтоон ажиллаж байна.</p> <p>Цагдаагийн байгууллагын нэгдсэн системийн “Захиргааны тоо бүртгэл”-ийн захиргааны хяналтад байгаа этгээд цэсэнд өөрчлөлт оруулахаар 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 13-2/1170 дугаартай албан бичгээр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас саналыг авч Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба руу 13/1437 дугаартай албан бичгээр санд өөрчлөлт оруулах саналыг хүргүүлж шийдвэрлүүлэн ашиглаж байна.</p>	70
49.	Иргэдийн оролцоотой замын хөдөлгөөний хяналтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд E-Police цахим програм ашиглан замын	Замын хөдөлгөөний дүрэм баримталдаггүй жолооч нарыг иргэд, олон нийтийн	Тээврийн цагдаагийн албанаас нийслэлийн Замын хөдөлгөөний удирдлагын төвтэй хамтран “E-Police” аппликейшныг 2018 оноос	100

	<p>хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг хангуулах ажлыг судалж, боловсронгуй болгох. /ГХУСА33-3.4/</p>	<p>тусламжтайгаар илрүүлж, дүрэм баримтлах хандлагыг төлөвшүүлнэ.</p>	<p>нэвтрүүлсэн бөгөөд 2022 онд “E-police” аппликейшн”-ы талаар иргэд, олон нийтэд сурталчлах чиглэлээр дараах ажлыг зохион байгуулсан. Тухайлбал: Тус албаны Урьдчилан сэргийлэх хэлтсээс 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 14а/866 дугаартай албан бичгийг харьяа газар, хэлтэс тасагт хүргүүлж, нийт алба хаагчдын гар утсанд “E-Police” гар утсаны аппликейшинг суулгах ажлыг зохион байгуулж, хяналт тавих үйл ажиллагаанд ашиглаж хэвшсэн.</p> <p>“E-Police” аппликейшныг ашиглах эрх зүйн орчны бүрдүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34.3-т заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтран батлах “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг урамшуулах журам”-ын төслийг боловсруулахад оролцож, хамтран ажиллаж, уг журам Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсээр хянагдаж, Цагдаагийн ерөнхий газраас 2021 оны 2/49 дугаартай албан бичгээр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд хүргүүлсэн.</p> <p>Замын хөдөлгөөний удирдлагын төв, “Go Smart” ХХК-тай хамтран “Иргэн бүр цагдаа” уриатай “E-Police апп” ашиглалтад энэ онд зөрчлийн давхардал үүсэх, цэс хэсэгт замын хөдөлгөөний дүрэм, аппликейшныг ашиглах заавар зэргийг нэмж хөгжүүлэлтийг хийж иргэдээс “E-Police апп”-д ирүүлсэн 88686 зөрчлийг баталгаажуулан тээврийн хэрэгслийн эзэмшигч, өмчлөгчийн бүртгэлтэй хаягаар шийтгэлийн хуудсыг хүргүүлж ажилласан.</p> <p>Цахим орчинд Замын хөдөлгөөний дүрэм зөрчиж буй талаар иргэдээс ирүүлсэн мэдээллийг тус албаны Мөрдөн шалгах газрын Зөрчил хянан шийдвэрлэх хэлтэстэй хамтран бүртгэн авч, нийт цахимаар ирсэн 657 зөрчилд арга хэмжээ тооцуулахаар зөрчил бүртгэгдсэн дүүрэг дэх замын цагдаагийн нэгжүүдэд хүргүүлж, хариуцлага тооцуулж, энэ талаар иргэдэд “Paparazzi Traffic Mongolia”, “Цахим замын цагдаа” болон “Тээврийн цагдаагийн алба” гэсэн цахим хаягуудаар нийт 160 удаа эргэн мэдээлж ажилласан.</p> <p>“Зөрчилд арга хэмжээ тооцсон” талаарх мэдээллийг байршуулах бүртээ “Иргэн та замын хөдөлгөөний дүрэм зөрчиж буй үйлдлийн талаарх мэдээллийг “E-Police” гар утасны аппликейшинг ашиглан илгээх боломжтой талаарх мэдээлэл, татах холбоосыг хамтад байршуулж ажилласан.</p> <p>Мөн “Дүрэмгүй жолооч нар таныг бухимдуулсаар байна уу?”, “E-police гар утасны ппликейшнийг сонгохыг зөвлөж байна” гэсэн гарчигтай мэдээллийг тус тус бэлтгэн албаны сайт, цахим хуудас болон өргөн нэвтрүүлгийн 5 телевизэд 5 удаа, богино долгионы 2 FM радиод 2 удаа, албаны болон бусад хэвлэл мэдээллийн 4 цахим сайтад 4 удаагийн мэдээллийг байршуулж, иргэд олон нийтэд сурталчилж ажилласан.</p>	
50.	<p>Замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх</p>	<p>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон нийтийн хандлага, мэдлэг</p>	<p>Тээврийн цагдаагийн албанаас замын хөдөлгөөний ачааллын нөхцөл байдал, олон нийтийн цагдаагийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагын талаар Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулж, хэлэлцүүлсний үр дүнд 2022 оны 01 дүгээр сарын 26–ний</p>	100

	<p>ажлын хүрээнд иргэдээс олон нийтийн байцаагчийг ажиллуулах. /ГХУСА33-3.5/</p>	<p>ойлголт нэмэгдэж, зөрчлийн гаралт буурна.</p>	<p>өдрийн 03 дугаар тогтоолоор замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон нийтийн цагдаагийн ажилтны орон тоог 32 байсныг 90 ажилтан байхаар тогтоож, олон нийтийн цагдаагийн ажилтны цалин урамшууллыг төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээний 09 дүгээр зэрэглэлийн 1 дүгээр шатлалын /ТТ-9.1/ дүйцүүлэн 641.363 /зургаан зуун дөчин нэгэн мянга гурван зуун жаран гурав/ төгрөг байх шийдвэрүүдийг гаргуулсан.</p> <p>Одоо тус албанд 67 олон нийтийн цагдааг 30 постод үүрэг гүйцэтгүүлж алба хаагчдын ажлын ачааллыг бууруулахад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p>	
<p>51.</p>	<p>Халаасны хулгайн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулах.</p>	<p>Халаасны хулгайн гэмт хэрэг буурсан байна.</p>	<p>Хулгайлах, Халаасны хулгайн гэмт хэргийн нөхцөл байдал, шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж 2022 оны эхний хагас жилд “Мал мах-Хяналт”, “Сар шинэ 2022”, “Илрүүлэлт оргодол”, “Шийдвэрлэлт”, “Сарбак”, “Арлын дугаар”, “Ломбард хяналт”, “Халаас”, “Бүртгэл” зэрэг ерөнхий болон тусгай арга хэмжээг зохион байгуулснаар нийслэлд 2022 оны эхний 05 сарын байдлаар Хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт 26,1 хувьтай ба урьд оны мөн үеийнхээс 1,0 хувиар, Халаасны хулгайн гэмт хэргийн илрүүлэлт 22,1 хувьтай ба 5,4 хувиар тус тус өссөн байна.</p> <p>Халаасны хулгайн гэмт хэргийн 5189 мэдээлэлд дүн шинжилгээ хийж, 26 бүлэг, 995 сэжигтэй этгээдийг тогтоон, бүлэглэлийн зураглал гаргаж, тэдгээрийн гэмт үйлдлийг баримтжуулж, хяналт тавин ажиллаж байна.</p> <p>“Халаасны хулгайн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” чиглэлээр ерөнхий боловсролын 1949 сурагч, “Улаанбаатар эрдэм” их сургуулийн 60 оюутан, алба хаагч, нийт 2009 иргэнд сургалт орж, мэдээ мэдээлэл өгч, богино хэмжээний шторк үзүүлж, дээрх төрлийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон илрүүлсэн хэрэг, зохион байгуулж буй арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийт 3 удаа мэдээллийг иргэд олон нийтэд хүргэсэн.</p> <p>Гэмт хэргийн улмаас алдагдсан гар утсыг техник технологи, программ хангамжийн дэвшлийг ашиглан хяналтад авах, гар утасны хулгайн гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэх, таслан зогсоход тулгамдаж буй асуудал сэдэвт хэлэлцүүлгийг 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдөр төрийн болон төрийн бус 13 байгууллагын 18 төлөөллийг оролцуулан зохион байгуулж, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын даргын зөвлөлийн 2 дугаар хуралдаанд “Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ” чиглэлээр мэдээлэл, танилцуулга хийж, мөн дээрх мэдээллийг Цагдаагийн Ерөнхий газрын даргын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.</p> <p>Мөн халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг хийж хэрэгжүүлэхээр Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 56 дугаартай захирамжаар</p>	<p>70</p>

			19.000.000 /Арван есөн / сая төгрөгийн санхүүжүүлтийг шийдвэрлүүлж, төсөв батлагдсаны дагуу 4 видео шторк, 10000 хэвлэмэл материал, сургалтын материалыг “Үнэний ташуур”, “Үнэний хурц туяа” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажиллаж байна.	
<b>Дөрөв: Соён гэгээрүүлэх чиглэлээр</b>				
52.	Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон соён гэгээрүүлэх чиглэлээр инфографик, шторк, контент болон цуврал нэвтрүүлэг бэлтгэж олон нийтэд түгээх. /ГХУСА33-4.1/	Тайлангийн хугацаанд инфографик 100, шторк 50, контент 50, цуврал нэвтрүүлэг 40-өөс доошгүйг бэлтгэж, олон нийтэд түгээсэн байна.	Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагааг сурталчлах, иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ мэдээллийг түгээх ажлын хүрээнд “Амрыг эрье” 15, 20, минутын нэвтрүүлгийн нийт 48 удаагийн дугаар бэлтгэж МҮОНТ-ийн 1, 2 дугаар сувгаар, Эх орон, Боловсрол, Etv, Tv-5, Tv-4, Tv-9, Otv, News Chanel, Сүлд зэрэг нийт 12 телевизээр <b>96</b> удаагийн давталттайгаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэн ажилласан.  Тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлд хийсэн судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн 82 удаагийн нэвтрүүлэг, 112 удаагийн гэмт хэргийн мэдээ, 72 удаагийн урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл бэлтгэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, мэдээ, мэдээллийг тухай бүр төвийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд түгээн ажилласан.	100
53.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэтгүүлчдэд зориулсан сургалт зохион байгуулах. /ГХУСА33-4.2/	Сургалтад хамруулж, үр дүнг тооцсон байна.	Цагдаагийн Ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэстэй хамтран хэвлэл, мэдээллийн байгууллагын 54 сурвалжлагч, сэтгүүлч нарт “Эрх зүйн боловсролыг дээшлүүлэх нь” сэдэвт сургалт зохион байгуулсан. Мөрөөдлийн шүхэр” аяны хүрээнд хүүхдийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгтэй холбоотой хэрэг сурвалжлах талаар сэтгүүлчдийг чадавхжуулах сургалт энэ оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 10:00-10:30 цагийн хооронд “Puma imperial” зочид буудалд зохион байгуулагдах үед “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг оролцоо, хамтын ажиллагаа” сэдвээр 21 сэтгүүлчдэд мэдээлэл өгч ажилласан. Мөн насанд хүрээгүй хүнийг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй “Сэрэмжлүүлье” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Монголын сайтуудын холбоотой хамтран энэ оны 05 дугаар сарын 03-ны өдөр хэвлэл мэдээллийн байгууллагын 250 сэтгүүлч, ажилтнуудад “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоо, анхаарах асуудал” сэдвээр мэдээлэл өгсөн. Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс энэ оны 11 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулсан “Гэмт хэрэг ба ёс зүй” сэдэвт 30 хэвлэл мэдээллийн ажилтан, сэтгүүлчдэд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагаа, хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг оролцоо, хамтын ажиллагаа” сэдвээр сургалт зохион байгуулсан.	100

54.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр үнэ төлбөргүйгээр яаралтай нийтэлж, нэвтрүүлэх. /ГХУСА33-4.4/	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд тогтмол хүргэнэ.	<p>Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд түргэн шуурхай хүргэх, хууль эрх зүйг сурталчлах зорилгоор Цагдаагийн байгууллагын албан ёсны <a href="http://www.police.gov.mn">www.police.gov.mn</a> сайтад байгууллага, алба хаагч, урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээтэй холбоотой 126 ярилцлага, цаг үе, үйл явдлын 251 мэдээ, мэдээлэл, бусад мэдээлэл 43 нийт 420 мэдээ, мэдээллийг бэлтгэн, хянан байршуулсан байна.</p> <p>Бэлтгэж нийтэлсэн 420 мэдээ, мэдээлэл нь нийт 342,722 удаагийн хандалттай, 1 мэдээлэл дунджаар 892 удаагийн хандалттай байна. Монгол Улсын нийт 2 сая 1 зуун мянган интернет хэрэглэгчийн 16.3 хувьд нь хүрч тархсан буюу 6 интернет хэрэглэгч тутмын 1 нь тус сайтын мэдээллийг үзсэн байх боломжит магадлалтай байна.</p> <p>Түүнчлэн Хэвлэл, мэдээллийн төвийн фэйсбүүк цахим хуудаст 1375 мэдээ мэдээллийг нийтлэн иргэд, олон нийтэд түгээснийг давхардсан тоогоор 34,335,934 /reach/ хандалттай, 1 мэдээлэл дунджаар 24.971 хандалттай байна. 391,129 /like and reaction/ хүн лайк дарж, 187.464 /share/ удаа хуваалцаж, 71.440 /comment/ хүн сэтгэгдэл үлдээсэн байна.</p> <p>Эрүүгийн цагдаагийн албанаас ирүүлсэн ASAP санд эрэн сурвалжлагдаж буй хүн, эд зүйлсийн талаарх эрэн сурвалжлагдаж буй 18, эрэн хайсан 15, олдсон 4, баривчилсан 9 хүний талаарх нийт 46 зурагт мэдээллийг төвийн фэйсбүүк хуудсанд тамгалан байршуулж, бусад мэдээллийн сайтуудад мэдээллэн олон нийтэд түгээсэн ба дээрх мэдээллүүдийн нийт тархалт давхардсан тоогоор 4,600,000 гаруй фэйсбүүк хэрэглэгчид хүрч, 7527 цахим хэрэглэгч бусадтай хуваалцаж, 2198 сэтгэгдэл үлдээсэн ба 15426 хүнд таалагдсан байна.</p>	100
55.	Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр алба хаагчдыг чадавхжуулах. /ГХУСА33-4.5/	Алба хаагчдыг сургалтад хамруулж, үр дүнг тооцсон байна.	<p>Хүний эрхийн үндэсний комисстой хамтран “Хүний эрхэд суурилсан хандлага” сэдэвт сургалтыг зохион байгуулж Мөрдөн байцаах алба, Хар тамхитай тэмцэх газар, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, орон нутаг дахь мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий 618 алба хаагчийг, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтэстэй хамтран “Хүний эрх ба алба хаагчийн эрх, үүрэг” сэдэвт 3 сарын хугацаатай бүсчилсэн сургалтыг 03 дугаар сарын 07-ны өдрөөс эхлүүлэн 37 анги, байгууллагын 7000 орчим алба хаагчийг, Сургалтын нэгдсэн төвтэй хамтран “Мөрдөгчийн харилцаа хандлага” сэдэвт сургалтыг 174 мөрдөгчдийн дунд 06 дугаар сарын 09-ны өдөр , Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилладаг алба хаагчдыг мэргэшүүлэх, сургагч багш бэлтгэх” чадавхжуулах сургалтыг тус тус зохион байгуулж, нийт 7792 алба хаагчдыг хамрууллаа.</p> <p>Америкийн нэгдсэн улсаас Монгол улсад суугаа элчин сайдын яамны Мөрдөн шалгах албаны атташе, Дэд консул Роберт Гуденкауфыг энэ оны 04 дүгээр сарын 14-ний өдөр хүлээн авч цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах чиг үүргийн хүрээнд хамтын ажиллагааг сайжруулах, цаашид</p>	100

			хамтран хэрэгжүүлэх асуудлын талаар ярилцан хүний эрх, эрүү шүүлтийн эсрэг сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна.	
56.	ЕБС-ийн сурагчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, үе шаттай тэмцээн зохион байгуулах. /ГХУСА33-4.6/	Улсын хэмжээнд зохион байгуулагдаж, үр дүнг тооцсон байна.	Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан А/253 /А/252 дугаар тушаалын дагуу сайн дурын бүлгэмийн ажиллах журмын хэрэгжилтийг хангах “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм”, “School police” буюу эцэг эхийн эргүүлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, сурталчлах чиглэлээр ерөнхий боловсролын сургуулийн 415 бүлгэмийн 4280 сурагч, 5975 иргэнд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Аймаг, дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран улсын хэмжээнд өсвөрийн сэргийлэгч бүлгэмийн гишүүдийг чадавхижуулах сургалтыг 21, чуулга уулзалт 2, Аха тэмцээн 2, “Томчуудад хэлэх бидний үг”, “Дэвжээ” тэмцээнийг 7 удаа тус тус зохион байгуулж, 2440 сурагчдыг хамруулж, хүүхдийн эрхийн тухай ойлголт мэдлэгийг нэмэгдүүлсэн байна.	90
57.	Төрийн алба хаагчдад төрийн, байгууллагын болон хувь хүний нууцтай холбоотой хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах. /ГХУСА33-4.7/	Сургалт зохион байгуулагдаж, үр дүнг тооцсон байна.	Цагдаагийн байгууллагын хэмжээнд “Баримт бичгийн нууц, хуурамч бичиг баримтыг таних нь”, “Баримт бичгийн хадгалалт, хамгаалалт, боловсруулалт”, “Төрийн болон албаны нууц”, “Төрийн болон албаны нууцын тухай хууль”, “Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал”, “Хувь хүний болон албаны нууцын тухай хуулийн үзэл баримтлал”, ЦБҮАЖ-ын “Төрийн болон албаны нууцыг хамгаалах” /код-114/, “Цагдаагийн байгууллагын албаны нууцын тухай” зэрэг 29 удаагийн сургалт зохион байгуулж, 2465 алба хаагчийг хамруулсан байна.	100
58.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл үзүүлж байна “Сэргийлэгч” нэвтрүүлгийг бэлтгэн, олон нийтэд хүргэх. /ГХУСА33-4.8/	Хуваарийн дагуу нэвтрүүлэг гарч, олон нийтийн хүртээл болсон байна.	Цагдаагийн ерөнхий газрын “Сүлд” чуулгатай хамтран “Миний баатар, миний найз цагдаа” сэдэвт богино хэмжээний видео бичлэг хийх, оролцох жүжигчид, эцэг, эх, хүүхэд, иргэдийг сонгох, шаардлагатай эд зүйлсийг байрлуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаж, Дотоод хэргийн их сургууль, Шангила зочид буудлын хажууд тус тус зураг авалт, монтаж хийлгүүлж, фэйсбүүк хуудасны “ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтэс” пэйж хуудсанд байрлуулахад 11,000 хүн үзэж, 2,800 хүн бусадтай хуваалцсан байна. “Social Room” студи, Сэтгэцийн эрүүл мэндийн төвтэй хамтран цахим гадуурхалд өртсөн хүүхдийн сэтгэл зүй нэртэй видео цуврал 4 контентыг бэлтгэн хүргэсэн.	100
59.	“Ногоон гэрэл-Цагаан шугам”, “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээний хөтөлбөрийг шинэчлэх, улсын хэмжээнд зохион байгуулах. /ГХУСА33-4.9/	Замын хөдөлгөөнд оролцогч хүүхдүүдийн анхаарал сэрэмж дээшилж, осол, гэмтлийн тохиолдол буурна.	Боловсролын ерөнхий газар, Монголын Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран сургуулийн өмнөх насны хүүхэд, эцэг, эхчүүдэд замын хөдөлгөөнд оролцох, зөв дадал олгох, хэвшүүлэх, зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль дүрмийн мэдлэг олгох зорилгоор “Замын хөдөлгөөний цагаан толгой 2022” тэмцээний хөтөлбөрийг шинэчлэн модуль сургалт хэлбэрт оруулж энэ оны 05 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулж орон нутаг, нийслэлээс шалгарсан 19 баг тамирчид оролцож, хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс багийн нийлбэр дүнгээр Баянзүрх, Баянгол	100

			<p>Сонгинохайрхан дүүрэг, Дундговь, Орхон аймгууд идэвхтэй сайн оролцож тэргүүн байранд шалгарсан.</p> <p>Бага насны хүүхдийг зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Ногоон гэрэл-Цагаан шугам 2022” тэмцээнийг зохион байгуулах хөтөлбөрийг шинэчлэн нутаг дэвсгэр хариуцсан Цагдаагийн байгууллагын Замын цагдаагийн нэгжүүдэд албан бичгээр мэдээлэл, ажлын чиглэл, удирдамжийн жишиг загварыг боловсруулан хүргүүлснээр нутаг дэвсгэр хариуцсан Цагдаагийн байгууллагын замын цагдаагийн нэгжүүд энэ оны 11 дүгээр сард хариуцсан нутаг дэвсгэртээ тус тус зохион байгуулж, хүүхэд багачуудад замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгоод байна.</p>	
60.	<p>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, салбар зөвлөлийн гишүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг сайжруулах, сургалт зохион байгуулах. /ГХУСА33-4.10/</p>	<p>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэний нийгмийн байгууллагын оролцоо нэмэгдэж, урьдчилан сэргийлэх ажлын чанарт ахиц гарсан байна.</p>	<p>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 33 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах, олон нийтийн санал, санаачилгыг дэмжих, олон нийтийн байцаагч ажиллуулах зэргээр иргэдийн оролцоог нэмэгдүүлж, олон нийтийн санал санаачилгыг дэмжиж 2022 онд 198181 иргэн, төрийн байгууллага 8655, төрийн бус байгууллага 2428, аж ахуйн нэгж, байгууллагын 10495, олон нийтийн цагдаа 1350, олон нийтийн байцаагч 1480 хүн, хөршийн хяналтын 3548 бүлэг, малчдын бүлэг, холбоо, нөхөрлөл 819, оюутан цагдаа 392, өсвөрийн сэргийлэгч-1394, хамтарсан багийн 2092, ерөнхий боловсролын 1946 сургуулийн “School police” эргүүлийн иргэдийг тус тус татан оролцуулж мэргэжил, арга зүйгээр хангаж ажилласан байна.</p>	100
Нийт-60 ажил, арга хэмжээнээс хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй-4 ажил байна. Дундаж үнэлгээ				96.6

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР